



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗАР

2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ

2024 ОН

АГУУЛГА

УДИРТГАЛ	3
НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН	5
1.1. Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрт нийслэл хариуцан хэрэгжүүлэхээр тусгагдсан заалтуудын хэрэгжилт	5
1.2. “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангахад чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөж, зохион байгуулсан байдал	5
1.3. Улсын онцгой комисс, Нийслэлийн онцгой комисс, Нийслэлийн Засаг даргын захирамж, албан даалгавар, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэл, Нийслэлийн удирдлага, газрын удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, үр дүн	9
1.4. Нийслэлийн Засаг даргаас Засгийн газрын гишүүд, салбарын сайд нартай байгуулсан хамтран ажиллах гэрээнд заасан зорилтуудын хэрэгжилт, үр дүн, тайлагнасан байдал	18
1.5. Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх чиглэлээр хийсэн ажил, үр дүн	19
ХОЁР. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	19
2.1. Байгууллагын дүрмээр хүлээсэн үндсэн чиг үүргийн хэрэгжилт	19
2.1.1. Барилга, дэд бүтцийн салбарын төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх:	19
2.1.2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг зохион байгуулах	37
2.2. Газрын үндсэн чиг үүрэгтэй холбогдох хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр хэрэгжүүлсэн ажил, үр дүн	40
2.3. Үндсэн чиг үүргийн хүрээнд нийслэлийн удирдлагад хууль, эрх зүйн дэмжлэг үзүүлэх, хууль, шүүхийн өмнө төлөөлөх	40
2.4. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн;	41
2.5. Байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө болон нийслэлийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөний биелэлт, төсвийн гүйцэтгэл	41
2.6. Төрийн захиргааны албан хаагчдын ажлын гүйцэтгэл, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэсэн байдал	42
2.7. Байгууллагын үйл ажиллагааны зардал хямдруулах, төсөв хэмнэх чиглэлээр зохион байгуулж, үр дүнд хүрсэн бодитой ажил	42
2.8. Хяналт шалгалтын байгууллагаас ирүүлсэн санал зөвлөмж, түүнийг хэрэгжүүлсэн байдал	43
2.9. Үндсэн чиг үүргийн биелэлт, үр дүнд хийсэн дотоод аудит, хяналт шалгалт, дүгнэлт	43
2.10. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт	45
2.11. Архив, албан хэрэг хөтлөлт, хариутай болон хариугүй албан бичгийн шийдвэрлэлтийн байдал	47
2.12. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт	49
2.13. Байгууллагуудын дотоод удирдлагын программын ашиглалт, үр дүн	51
2.14. Ажилтан, албан хаагчдын ажлын сахилга хариуцлага, байгууллагын соёл, дэг журмыг сахиулах, ажлын бүтээмжийг дээшлүүлсэн байдал, үр дүн	52
2.15. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	53
ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ	54
3.1. Байгууллагын ил тод байдлыг хангах чиглэлээр хийж хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн	54
3.2. Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангасан байдал буюу шилэн дансны хөтлөлтийн байдал, үр дүн	55
ДӨРӨВ. БУСАД МЭДЭЭЛЭЛ	56
4.1. Олон нийтийн арга хэмжээ	56
4.2. Санаачлан хэрэгжүүлсэн онцлох ажил	57
ТАВ. ДҮГНЭЛТ	62
ЗУРГАА. ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ, САНАЛ	62

НИЙСЛЭЛИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗРЫН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2024 оны 12 дугаар сарын 25

Улаанбаатар хот

УДИРТГАЛ

Хотын стандартыг боловсруулж батлуулах, барилга дэд бүтцийн салбарт хяналт тавих зэрэг өргөн цар хүрээтэй чиг үүргийг хэрэгжүүлдэг Хотын стандарт, хяналтын газрыг Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 81 дүгээр тогтоол, нийслэлийн Засаг даргын 2024 оны А/430 дугаар захирамжийн дагуу өөрчлөн байгуулж, хотын стандартыг боловсруулж батлуулахтай холбоотой чиг үүргийг өөр байгууллагад шилжүүлж, барилга дэд бүтэц, орчны аюулгүй байдлын чиглэлээр төрийн хяналтын чиг үүргийг дагнан хэрэгжүүлж эхэлсэн нь тус газрын 2024 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд гарсан голлох өөрчлөлт байв.

Төрийн хяналт шалгалтын чиг үүргийн хувьд нийслэлийн Засаг даргын захирамж, газрын даргын баталсан удирдамжийн хүрээнд нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудтай хамтран барилга угсралт, тохижилт бүтээн байгуулалтын үйл ажиллагаанд хууль тогтоомж, стандарт, нормыг мөрдүүлэх, гарч буй зөрчил, орчны аюулгүй байдлыг нэгдсэн байдлаар арилгуулах томоохон ажлуудыг зохион байгуулав.

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах чиг үүргийн хувьд комиссын үйл ажиллагааг төлбөртэй болгох асуудлаар зардлын хэмжээг барилга байгууламжийн төвөгшил, хэмжээг харгалзан тогтоох талаар тооцоо гаргаж шийдвэрийн төслийг Барилга, хот байгуулалтын яаманд уламжилж, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/503 дугаар захирамжаар комиссын бүрэлдэхүүнийг шинэчилж төлөөллийн тоог бууруулан төрийн үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад түргэн шуурхай үзүүлж байна.

БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Эрхэм зорилго: Нийслэлийн иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах зорилтын хүрээнд хот байгуулалт, барилга, дэд бүтцийн салбарт хэрэгжих бүтээн байгуулалт, ашиглалт засварын ажил, үйлчилгээнд хууль тогтоомж, үндэсний болон хотын стандарт, нормыг мөрдүүлж, төрийн хяналт шалгалтын үр нөлөөтэй байдлыг сайжруулах нь тус газрын эрхэм зорилго болно.

Үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг: Барилга, хот байгуулалт, дэд бүтэц, газрын харилцаа, уг салбарт орчны аюулгүй байдлыг хангуулах хүрээнд төрийн хяналт шалгалтын чиг үүргийг хэрэгжүүлж, иргэн, хуулийн этгээдээс гаргасан өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж, холбогдох хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн акт, техникийн зохицуулалт, үндэсний болон хотын стандартын хэрэгжилтэд хяналт тавина.

Газрын дүрмийг Нийслэлийн Засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн А/654 дүгээр захирамжаар шинэчлэн батлуулж, дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

- барилга, хот байгуулалт, дэд бүтцийн салбарын төрийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх;
- хууль тогтоомж, стандарт, норм, дүрмийг мөрдүүлэхэд төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг мэдээлэл, сургалт, арга зүйгээр хангах, зөвлөн туслах, сурталчлан таниулах;
- барилга, дэд бүтцийн салбарын хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн баримт бичиг, үндэсний болон хотын стандарт, норм дүрмийн хэрэгжилтийн байдлыг судалж, эрсдэлийн үнэлгээ хийх;

- Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Хяналт шалгалт хийх нийтлэг журмын дагуу төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх, гүйцэтгэлийн хяналт шалгалтыг зохион байгуулж, түүний үр дүнд илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээг авах;
- нийслэлийн хэмжээнд баригдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах чиг үүргийг хэрэгжүүлэх;
- барилга байгууламж, их засвар тохижилтын ажлыг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах;
- барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлтийг баталгаажуулах;
- ашиглалтад орсон барилга байгууламжийн талаарх мэдээллийг нэгтгэн, холбогдох мэдээллийн санг баяжуулах.


Газрын бүтэц, орон тоо: Нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн “Хяналт шалгалтын газрын бүтэц орон тооны хязгаарыг шинэчлэн батлах тухай” А/596 дугаар захирамжаар тус газар нь 6 нэгж, 98 хүртэлх орон тоог баталснаас 2024 оны сүүлийн хагас жилийн байдлаар нийт 55 албан хаагчдын бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Схем. Газрын бүтэц, зохион байгуулалт



Одоо ажиллаж буй орон тооны мэдээлэл:

Д/д	Хэлтэс	Батлагдсан орон тоо	Үүнээс
1	Газрын дарга	1	1
2	Захиргаа, санхүүгийн хэлтэс	21	12
3	Дотоод хяналт, шинжилгээний хэлтэс	6	3
4	Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтэс	13	9
5	Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтэс	28	16
6	Дэд бүтцийн стандарт хяналтын хэлтэс	20	13
7	Орчны аюулгүй байдлын хяналтын хэлтэс	9	2
Нийт:		98	55 (56.1%)



- Удирдах-6
- Төрийн захиргаа-31 (Улсын байцаагч-21)
- Төрийн үйлчилгээ-18



НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

1.1. Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрт нийслэл хариуцан хэрэгжүүлэхээр тусгагдсан заалтуудын хэрэгжилт

Дээд газраас ирүүлсэн тогтоол, шийдвэрийг газрын даргад танилцуулан цохолт хийлгэж, Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ын дагуу бүртгэл-хяналтын карт хөтөлж хариуцан шийдвэрлэх нэгж, албан хаагчдад шилжүүлж шийдвэрийг хяналтад авч ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу газрын үндсэн үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг сар бүр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт хүргүүлж, тайлагнасан.

2024 оны жилийн эцсийн байдлаар газрын хэмжээнд хяналтад авсан нийт 45 хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 63 заалтын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд нэгдсэн дүнгээр 94.4 хувийн хэрэгжилттэй байна.

Хүснэгт. Дээд газрын тогтоол шийдвэрийн биелэлт

Агуулга		Бүгд	Үүнээс:								
			Монгол Улсын хууль	Улсын Их Хурлын тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	Засгийн газрын тогтоол	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	Засгийн газрын болон Ерөнхий сайдын албан даалгавар	Хүний эрхийн Үндэсний Комиссын зөвлөмж	Нийслэлийн Засаг даргын захирамж	НЗД-ын Зөвлөлийн хуралдааны тэмдэглэл
Хяналтад авсан нийт шийдвэрийн тоо		45	4	1	1	3	3	2	1	25	5
Хяналтад авсан нийт зүйл, заалтын тоо		63	11	1	1	4	3	2	5	25	11
Үүнээс	Биелсэн 90-100	54	11	1	1	2	1	2	5	22	9
	Хэрэгжих шатанд										
	70	5	-	-	-	2	1	-	-	1	1
	50	1	-	-	-	-	-	-	-	1	-
	30	2	-	-	-	-	1	-	-	-	1
	Хугацаа болоогүй	1	-	-	-	-	-	-	-	1	-
	Тасарсан	0	-	-	-	-	-	-	-	-	-
Биелэлтийн дүн /хувь/		94.4	99	100	90	82.5	63.3	100	96	96.6	96

1.2. “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангахад чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөж, зохион байгуулсан байдал

Улс, нийслэлийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт газрын чиг үүрэгт хамаарах зорилт, арга хэмжээг газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “**Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам**”-ын дагуу улирал, хагас жил тутам

хэрэгжилтийг нэгтгэн газрын даргын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцэж Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тайлагнасан.

2024 оны эхний хагаст нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын бүтэц, чиг үүрэгт өөрчлөлт орж “Хотын стандарт”-ын чиг үүрэг Хот байгуулалт, хотын стандартын газарт шилжсэнтэй холбогдуулан бодлогын баримт бичигт тусгагдсан зарим арга хэмжээний хэрэгжилтийг тус газар хариуцан ажиллаж байна.

Хүснэгт. Бодлогын баримт бичгийн хэрэгжилт

№	Бодлогын баримт бичиг	Арга хэмжээ /тоо/		Хариуцах	Хэрэгжилтийн хувь
		ХСХГ	ХШГ		
1	“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого	4	1	Хамтран хэрэгжүүлэх 1 арга хэмжээ	100%
2	Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	5	2	Хамтран хэрэгжүүлэх 2 арга хэмжээ	95%
3	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	8	4	Хамтран хэрэгжүүлэх 4 арга хэмжээ	97.5%
4	Нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөө	6	2	Үндсэн хэрэгжүүлэх 2 арга хэмжээ	90%
Нийт:		28	9	Х-7, Ү-2	95.6%

Бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан Хяналт шалгалтын газарт холбогдох зорилт, арга хэмжээний 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтийн тайлан болон хүрсэн үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 01/1042 дугаар албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт хүргүүлсэн. Үндсэн хэрэгжүүлэх болон хамтран хэрэгжүүлэх нийт 9 арга хэмжээний хэрэгжилт 95.6 хувь буюу “Бүрэн хэрэгжсэн” байна. Үүнээс үндсэн хэрэгжүүлэх 2 арга хэмжээ 90 хувь, хамтран хэрэгжүүлэх 12 арга хэмжээ 97.5 хувийн биелэлттэй хэрэгжилтийг хангаж ажиллалаа.

Зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг дараах байдлаар хураангуйлав.

➤ **“Барилга, дэд бүтцийн болон бусад хяналтын салбарын хяналт, шалгалтын тогтолцоог сайжруулах хөтөлбөр” боловсруулах хүрээнд:** /Нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөө/

Барилга, дэд бүтцийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа бизнес эрхлэгч иргэн, хуулийн этгээдийн үүрэг хариуцлагыг өндөржүүлэх, хяналтын байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, төрийн бус байгууллага, олон нийтийн хамтын хяналтын тогтолцоог бэхжүүлэх, хяналт шалгалтын давхардлыг арилгаж, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хяналт шалгалтын үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор “Барилга, дэд бүтцийн болон бусад хяналтын салбарын хяналт, шалгалтын тогтолцоог сайжруулах хөтөлбөр боловсруулах” ажлын хэсгийг Хяналт шалгалтын газрын даргын 2024 оны А/30 дугаар тушаалаар байгуулж, хөтөлбөрийн хүрээнд 5 зорилт, 16 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төслийг боловсруулсан.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх дараах үндсэн 5 зорилтыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Төрийн хяналт шалгалтын хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх, хариуцлагын тогтолцоог сайжруулах хүрээнд эрх зүйн орчныг боловсронгуй болгох;
2. Төрийн хяналт шалгалтын үйл ажиллагаанд цахим хяналтыг нэвтрүүлэх;

3. Төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын уялдаа холбоог сайжруулж, хамтын хяналтын тогтолцоог бэхжүүлэх;
4. Хяналт шалгалтын байгууллагын мэргэшсэн, тогтвортой хүний нөөцийг бүрдүүлэх, санхүүгийн хувьд чадавхтай, хараат бус, бие даасан тогтолцоог бүрдүүлэх;
5. Дэвшилтэт техник технологи бүхий лабораторийг бий болгож, баталгаажсан үр дүн бүхий хяналтын үйлчилгээг иргэн, аж ахуй нэгж байгууллагад үзүүлэх;

Хөтөлбөрийн төслийг Нийслэлийн засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг ханган ажиллаж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж батлуулахаар танилцуулга, холбогдох шийдвэрийг төслийг хянуулж байна.

➤ **Хот төлөвлөх, хот байгуулах үйл ажиллагаанд мөрддөг стандартын хэрэгжилтэд хяналт тавих, стандартын дагуу орчны аюулгүй байдлыг хангуулах хүрээнд:** /НЗДҮАХ-6.1.5.1, НХТЖҮЧ-9.5.3/

Нийслэлийн хэмжээнд иргэдийн эрүүл, аюулгүй орчинд ажиллах, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилтын хүрээнд барилга, дэд бүтцийн салбарын бүтээн байгуулалтын бүхий л үе шатанд хууль тогтоомж, дүрэм журам, стандарт нормыг мөрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн дараах ажлуудыг зохион байгуулав. Үүнд:

- 2024 оныг “Тохижилт-Бүтээн байгуулалтын жил” болгон зарласантай холбогдуулан хотын стандартыг мөрдүүлэх, сурталчлан таниулах, хяналт шалгалтын үйл ажиллагаанд хамтран ажиллах талаар нийслэлийн нутгийн захиргааны 26 байгууллагатай уулзалт зохион байгуулж нийт 266 албан хаагч оролцсон байна.
- Иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад батлагдсан хотын стандартыг сурталчлан таниулах, хэрэгжилтийг хангуулах зорилгоор дүүргүүдтэй хамтран нийслэлд үйл ажиллагаа эрхэлж байгаа СӨХ-дын 478 төлөөлөл, худалдаа үйлчилгээ эрхлэгч 184 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөллийг хамруулж сургалт зохион байгуулав.
- Нийслэлийн Засаг даргын 2024 оны “Хууль тогтоомж, хотын стандартыг мөрдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” А/367 дугаар захирамжийн хүрээнд хотын гол магистрал зам дагуух нийтийн эзэмшлийн зам талбайд хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг хангуулах 5 дэд ажлын хэсгийн хүрээнд хяналт шалгалт зохион байгуулж, 39 байршилд орчны хог хаягдал болон хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангуулж, 43 байршилд барилгын түр хашааг стандартын дагуу солиулж, худалдаа, үйлчилгээний 72 байгууллагын гадна хаягийг хотын стандартын дагуу шинэчлэн сайжруулж, өнгө үзэмжгүй 80 гадна хаяг, зар сурталчилгааны байгууламжийг буулгав.
- Газрын даргын баталсан 2024 оны “Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” 02-13-01/023/01 дугаартай удирдамжийн хүрээнд барилга угсралтын ажил гүйцэтгэж буй нийт 227 иргэн, ААНБ-уудын үйл ажиллагаанд хяналт тавьж барилгын түр хашааг стандартад нийцүүлэх, орчны аюулгүй байдлыг хангуулах, барилгын хог хаягдлыг цэвэрлэж ачуулах, ХАБЭА-ын шаардлагыг хангуулах талаар хугацаатай үүрэг даалгавар өгч гүйцэтгэлийг шалгаж байна. Уг ажлын хүрээнд зөвшөөрөлгүй барилга 21, нийтийн эзэмшлийн зам талбайг хашаалсан, орц гарц чөлөөлж нийтийн эзэмшил болгох шаардлагатай 38 байршлын судалгааг гаргасан.

- Нийтийн эзэмшлийн зам талбайн ил задгай холболттой нийт 399 гэрэлтүүлгийн шонг тагжуулж, 27 шонг тэгшлүүлж, 4370 метр сип кабелийг цэгцэлж, 204 шонг будаж өнгө үзэмжийг сэргээж, 2376 метр шилэн кабель буулгаж цэгцлүүлэн аюулгүй байдлыг хангуулсан.
- Нийслэлийн хэмжээнд шатахуун, шингэрүүлсэн шатдаг хийн худалдаа эрхэлдэг 42 аж ахуйн нэгжид мэдэгдэл хүргүүлж, 94 шатахуун түгээх станц, 16 шингэрүүлсэн шатдаг хийгээр автомашин цэнэглэдэг станцын гадна орчныг цэвэрлүүлж, тээврийн хэрэгслийн орц гарцын тэмдэг тэмдэглэгээг тодруулж, өнгө үзэмжийг сайжруулав.

➤ **Иргэд, олон нийтэд биеийн тамир, спортын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, амарч зугаалах тав тухтай орчныг бүрдүүлэх зорилгоор стандартад нийцсэн амралт, спорт, хүүхдийн тоглоомын талбайг байгуулах, ашиглалтад оруулах хүрээнд: /НЗДҮАХ-5.1.2/**

Улс, нийслэлийн төсвийн хөрөнгөөр Нийслэлийн хөрөнгө оруулалтын газраас захиалагчийн хяналт хэрэгжүүлж ажилласан амралт, спорт, хүүхдийн тоглоомын талбайн тохижилтын ажлын 109 хүсэлтийг судалж, ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг зохион байгуулсан. Үүнд:

- Амралтын талбайн тохижилт 8;
- Хүүхдийн тоглоомын талбайн тохижилт 29;
- 3*3 сагсан бөмбөгийн талбай 72.

➤ **Төрийн болон нийгмийн үйлчилгээний барилгыг хүртээмжтэй дэд бүтцийн стандартад нийцүүлэх хүрээнд: /НЗДҮАХ-6.1.5.2/**

- Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Салбарын хяналтын газрын улсын ерөнхий байцаагчийн 2024 оны 02-00/02 дугаартай удирдамжийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан хэрэгцээ, шаардлагыг хангуулах зорилгоор төрийн болон олон нийт, нийтийн орон сууцны зориулалттай барилгын ашиглалтын байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийсэн. Барилга байгууламжийн орц, гарц, дотор зохион байгуулалт, гадна тохижилт нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зорчих, хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангаагүй зөрчил дутагдал түгээмэл илэрч Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагчийн зөвлөмжийг төрийн болон орон сууц, олон нийтийн зориулалттай барилгын эзэмшигч өмчлөгч, ашиглагчдад хүргүүлсэн.

- Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” А/503 дугаар захирамжийн дагуу барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах дараах 3 байгууллагын төлөөллийг тогтмол оролцуулж байна. Үүнд:

- Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо;
- Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо;
- Хан-Уул дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо.


2024 онд нийт 392 барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг зохион байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүртээмжийг стандарт, норм дүрмийн дагуу хангуулах чиглэлээр барилгын захиалагч, гүйцэтгэгчдэд үүрэг даалгавар өгч, биелэлтийг хангуулж ажиллав.

1.3. Улсын онцгой комисс, Нийслэлийн онцгой комисс, Нийслэлийн Засаг даргын захирамж, албан даалгавар, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэл, Нийслэлийн удирдлага, газрын удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, үр дүн

1.3.1. Улсын онцгой комиссын шийдвэрийн хэрэгжилт:

Улсын онцгой комиссын даргын 2024 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” 01 дүгээр тушаал, Улсын Онцгой комиссын нарийн бичгийн даргын баталсан удирдамжийн дагуу шатахуун, хий зэрэг тэсэрч дэлбэрэх аюултай бодисын хадгалалт, тээвэрлэлт, түгээлтийн үйл ажиллагаа нь стандарт, норм, дүрэм нь аюулгүй байдлын шаардлага хангаж байгаа эсэхэд 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдрөөс 03 дугаар сарын 15-ны өдрүүдэд хяналт шалгалтыг зохион байгуулж, дүн мэдээг Улсын Онцгой комисст хүргүүлэв. Үүнд:

➤ Нийслэлийн нутаг дэвсгэрт газрын тосны бүтээгдэхүүний хадгалалт, түгээлт, тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг 41 аж ахуйн нэгжийн 22 шатахуун хадгалах агуулах, 284 шатахуун түгээх станц, 57 автомашин хийгээр цэнэглэх станц, 5 хий цэнэглэх станцын үйл ажиллагаанд шалгалт хийсэн. АХЦС-ууд ил сав ашиглаж байгаа нь хий алдагдсан тохиолдолд галын аюул осол үүсэх эрсдэлтэй бөгөөд аюулгүй зай хэмжээ зөрчиж хүүхдийн цэцэрлэг, худалдаа үйлчилгээний барилгатай ойр баригдсан байна.



Хот байгуулалтын мэдээллийн санд бүртгэгдээгүй 142 ШТС, АХЦС-уудыг байр зүйн зураг хийлгүүлж, мэдээллийн санд оруулах мэдэгдлийг хүргүүлсэн. Хяналт шалгалт хийсэн танилцуулга, цаашид авах арга хэмжээний саналыг 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 01/318 дугаар албан бичгээр Улсын онцгой комиссын ажлын албанд хүргүүлсэн.

➤ Аюултай ачаа тээврийн үйл ажиллагаа явуулж буй 17 аж ахуй нэгжийн 251 тээврийн хэрэгслийн техникийн шаардлага, тээвэрлэлтийн нөхцөлийг хангасан эсэхэд шалгалт хийж, “Авто тээврийн тухай хууль”, “Авто тээврийн хэрэгслээр ачаа тээвэрлэх дүрэм”, “Авто тээврийн хэрэгслээр хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд аюул, хохирол учруулж болзошгүй ачаа тээвэрлэх журам”-ын хэрэгжилтийг хангуулах тухай улсын /ахлах/ байцаагчийн 173 заалт бүхий 17 албан шаардлага хүргүүлсэн.




1.3.2. Нийслэлийн онцгой комиссын шийдвэрийн хэрэгжилт:

Нийслэлийн Онцгой комиссын 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 03 дугаар хуралдаанаас гарсан шийдвэрийн дагуу Геодези усны барилга байгууламжийн газар ОНӨААТҮГ-тай хамтран 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрөөс 03 дугаар сарын 05-ны өдрийн хооронд Баянзүрх, Чингэлтэй, Сүхбаатар дүүргүүдийн шар усны үер болох эрсдэлтэй Сэлбэ гол дагуу далан сувгуудад хяналт тавьж, илэрсэн зөрчил дутагдлуудыг арилгах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг зохион байгуулсан.

Нийтийн эзэмшлийн гудамж зам талбай, далан суваг, гуу жалга, борооны ус зайлуулах барилга байгууламжийн цэвэрлэгээ хангалтгүй, инженерийн шугам сүлжээг далан дотор зөвшөөрөлгүй суурилуулж далангийн гаргалгаа бөглөрч ус нэвтрүүлэх чадварыг алдагдуулж, шар усны үеийн аюул учрах эрсдэл үүсэж, улмаар хөрс, усны бохирдол ихсэж, иргэдийн эрүүл аюулгүй амьдрах орчин нөхцөлд сөргөөр нөлөөлөх зөрчлүүд илэрч байна. Шар усны үер болон уруйн усны үерийн аюулаас урьдчилан сэргийлэх талаар Барилгын техникийн хяналтын улсын байцаагчийн 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 02-013-02/041/11 дугаартай зөвлөмж боловсруулж дүүргүүдийн Засаг дарга нарт хүргүүлсэн.

1.3.3. Нийслэлийн Засаг даргын захирамжийн хэрэгжилт:

Хагас жилийн байдлаар нийслэлийн Засаг даргаас батлагдсан нийт 42 захирамжийн хүрээнд холбогдох үйл ажиллагааг зохион байгуулан хэрэгжилтийг хангуулж ажиллав. Чиг үүргийн хүрээнд 4 захирамж батлуулж, захирамжаар байгуулагдсан нийт 40 ажлын хэсгийн бүрэлдэхүүнд газрын удирдлага, албан хаагчид томилогдон ажилласан байна.



Газрын чиг үүргийн хүрээнд хариуцах захирамжийн биелэлтийг тухай бүр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт хүргүүлж тайлагнасан.

Д/д	Батлагдсан огноо	Дугаар	Захирамжийн нэр	Үр дүн
1	2024.03.26	А/309	Захиргааны актыг түр түдгэлзүүлэх тухай	Хан-Уул дүүргийн 15 дугаар хороо, Төв цэнгэлдэх хүрээлэн орчмын нягтаршлыг бууруулах тухай асуудлаар Мөнх сан ХХК-д олгогдсон 4, 10, 24 давхар бүхий барилгын төлөвлөлт, холбогдох баримт бичигт хяналт шалгалт хийж, барилга угсралтын үйл ажиллагааг түр зогсоосон. Хяналт шалгалтаар зөрчил илрээгүй тул

				2024 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн А/998 дугаар захирамжаар хүчингүй болгосон.
2	2024.03.26	A/310	Ажлын хэсэг байгуулах тухай (Олд консракшн ХХК)	Тухайн барилга байгууламжид үзлэг шалгалт хийж, Олд констракшн ХХК-д холбогдуулан зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг явуулж, Зөрчлийн тухай хуулийн дагуу торгуулийн арга хэмжээг авч, хугацаатай албан даалгавар хүргүүлж, шүүхийн шийдвэр гүйцэтгэх журмаар шийдвэрлэхээр Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхэд хүргүүлсэн.
3	2024.04.03	A/367	Хууль тогтоомж, хотын стандартыг мөрдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай	Хотын гол магистрал зам дагуух нийтийн эзэмшлийн зам талбайд хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг хангуулах нэгдсэн хяналт шалгалтад 25 албан хаагч оролцож, илэрсэн зөрчил дутагдлыг газар дээр нь арилгуулах хүрээнд иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад нийт 248 зөвлөмж, 172 мэдэгдэх хуудас, 16 албан шаардлага хүргүүлж зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажиллав.
4	2024.05.03	A/503	Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүн шинэчлэн батлах тухай	Барилга байгууламжийг ашиглалтад оруулахад 15 байгууллагын 17 төлөөлөл комиссын гишүүнээр ажилладаг байсан бол уг захирамжаар 13 байгууллагын 16 төлөөлөл байхаар шинэчлэн батлуулсан.
5	2024.08.26	A/1022	Хууль тогтоомж, хотын стандартыг мөрдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай	Ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар ажиллан 2024 оны 09 дүгээр сарын 12 өдөр хурал зохион байгуулж, 22 байгууллагын 24 төлөөлөл оролцсон. Дүүрэг тус бүрт дүүргийн Засаг даргын захирамжаар дэд ажлын хэсэг байгуулж, стандарт норм, журам зөрчсөн зөрчлийг газар дээр нь арилгуулж, холбогдох арга хэмжээг авч ажилласан.
6	2024.10.21	A/1226	Барилга акталж, данснаас хасах тухай	Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагчийн “Барилгын ашиглалтын төлөв байдлын тухай” дүгнэлтээр ашиглалтын шаардлага хангахгүй болсныг тогтоож, Налайх дүүргийн ЗДТГ-т хүргүүлж тус дүүргийн 1 дүгээр хороонд байрлах Соёлын төвийн барилгыг буулгаж дууссан.
7	2024.12.04	A/1459	Ажлын хэсэг байгуулах тухай	Төрийн хяналт шалгалтын тухай хууль болон холбогдох 5 хууль тогтоомжийн 15 зүйл, заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг нэгтгэн боловсруулж, ажлын хэсгийн дарга Нийслэлийн Засаг даргын нэгдүгээр орлогч Т.Даваадалайд танилцуулахаар бэлтгэл ажлыг хангасан.

Нийслэлийн Засаг даргын “2024 оныг Тохижилт-Бүтээн байгуулалтын жил” болгон зарлах тухай А/01 дүгээр захирамжийн хэрэгжилт:

Тохижилт-Бүтээн байгуулалтын жил болгон зарласантай холбогдуулан 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрөөс 2024 оны 03 дугаар сарын 18-ны өдрүүдэд Боловсрол, соёл шинжлэх ухааны яам болон нийслэлийн нутгийн захиргааны нийт 26 байгууллагатай уулзалт зохион байгуулж, бүтээн байгуулалтын зураг төсөлд хотын стандартын хэм хэмжээг тусгах, баталгаажуулах, тохижилтын ажилд зөвлөмж арга зүйгээр хангах, сургалт зохион байгуулах, хяналт шалгалтын үйл ажиллагаанд хамтран ажилласан.




➤ **Сургалт, арга зүйгээр хангах ажлын хүрээнд:** Тохижилт бүтээн байгуулалт, барилга угсралтын ажил эхэлж байгаатай холбогдуулан хотын стандартыг сурталчлан таниулах, барилга байгууламжийн ашиглалтыг сайжруулах, хийн хэрэглээний аюулгүй байдлыг хангах, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор газрын даргын баталсан “Барилга байгууламжийн ашиглалт, хотын стандартын хэрэгжилтийг хангуулах тухай” сургалтын хөтөлбөрийн хүрээнд 2024 оны 3, 4 дүгээр сард нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа эрхэлж буй нийт **478 СӨХ** болон иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудын төлөөллийн хамруулан сургалт зохион байгуулж, арга зүйгээр хангаж ажиллалаа. Үүнээс:

- Хан-Уул дүүрэг -25,
- Сонгинохайрхан дүүрэг -46
- Баянгол дүүрэг -114,
- Чингэлтэй дүүрэг -58,
- Баянзүрх дүүрэг -150,
- Налайх, Багануур, Багахангай дүүрэг -42.



Сургалтын үеэр СӨХ-дын төлөөллүүдээс тулгамдаж буй асуудлын талаар барилгын, дэд бүтцийн хяналтын улсын /ахлах/ байцаагчид хууль тогтоомж, стандарт нормын талаар зөвлөмж, мэдээлэл өгч ажиллалаа.

➤ *Тохижилт бүтээн байгуулалтын ажилд хүндрэл учруулж буй хууль, дүрэм журмын судалгаа:* Нийслэлийн Засаг даргын эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч П.Сайнзориг даргын баталсан “Тохижилт бүтээн байгуулалтын ажил гүйцэтгэхэд хүндрэл учруулдаг, хөрөнгө оруулалтын ажлыг удаашруулж зогсоосон хууль, дүрэм журмын талаар судалж, шинэчлэн боловсруулах” дэд ажлын хэсгийн нарийн бичгээр ажиллаж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Амгалан ахалж ажилласан. Дэд ажлын хэсгийн хуралдааныг 2 удаа зохион байгуулж, тохижилт бүтээн байгуулалтын ажлын өнөөгийн байдал, холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулахаар талаар ажлын хэсгийн гишүүдийн саналыг нэгтгэн боловсруулсан. Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй 15 хууль, 4 тогтоол, 13 норм ба дүрэм нийт 32 эрх зүйн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулахаар 7 байгууллагаас санал ирүүлснээс дүн шинжилгээ хийж, Барилгын тухай хуульд 1 санал, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд 2 санал боловсруулж Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Амгаланд танилцуулж, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/01 дүгээр захирамжаар байгуулагдсан ерөнхий ажлын хэсэгт хүргүүлэв.



➤ *Стандарт, норм, дүрмийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд:* Хяналт шалгалтын газраас нийслэлийн нутгийн захиргааны байгууллага болон ашиглалт хариуцсан байгууллагуудтай 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдөр уулзалт зохион байгуулж, гэрэлтүүлгийн ашиглалт, угсралтын үйл ажиллагааг нийслэлийн хэмжээнд хариуцан ажиллаж буй нийт 17 аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагууд, 6 дүүргийн гэрэлтүүлэг хариуцсан мэргэжилтнүүд оролцлоо.



Уулзалтаар дараах ажлуудыг хийж хэрэгжүүлэхээр шийдвэрлэв. Үүнд:


- Өнгө үзэмжгүй, эвдэрч гэмтсэн, эзэн холбогдогч тодорхойгүй шонгийн судалгааг гаргах;

- Нийслэлийн нутаг дэвсгэрт байгаа өнгө үзэмжгүй, эвдэрч гэмтсэн, эзэн холбогдогч тодорхойгүй шонг буулгаж, зөрчлийг арилгуулах үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангуулах;
- Стандарт норм дүрмийг шинэчлэн сайжруулах талаарх саналыг авч холбогдох байгууллагад уламжлан хүргүүлэх;
- Зураг төсөвт, ажлын даалгавар боловсруулахад, угсралтын ажил гүйцэтгэхэд, ашиглалтад хүлээн авахад болон комисс хүлээн авсны дараах ашиглалтын үе шатанд батлагдсан стандартыг мөрдүүлэх талаар хариуцсан чиглэлийн хүрээнд хяналт тавьж хамтран ажиллахад онцгой анхааран, гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө тусгах.

Хууль норм, дүрэм стандартын хэрэгжилтийг хангаж ажиллах тухай мэдэгдлийг 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 01/355 дугаартай албан бичгээр нийт 17 аж ахуйн нэгж, байгууллагад хүргүүлж, хяналт тавьж ажиллав.

Нийслэлийн Засаг даргын 2024 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/310 дугаар захирамжийн хэрэгжилт:

Хан-Уул дүүргийн 11 дүгээр хороо, Зайсангийн аманд “Олд констракшн” ХХК-ийн гүйцэтгэсэн Астра вилла хотхоны С блок-ийн барилгын чанар, аюулгүй байдал, батлагдсан зураг төслийн дагуу баригдсан эсэхэд барилгын техник, хот төлөвлөлт, эрчим хүч (цахилгаан, дулаан), өргөх байгууламж, ус хангамж, ариутгах татуургын хяналтын нийт 6 чиглэлээр төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай удирдамж гарган 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрөөс эхлүүлж “Олд констракшн” ХХК-д захирамжийг танилцуулж, хяналт шалгалт хийх тухай мэдэгдэх хуудас хүргүүлсэн.



Гүйцэтгэгч “Олд констракшн” ХХК нь ашиглалтад оруулаагүй барилга байгууламжид айл оруулсан байгаа нь Барилгын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3 дэх заалт, Зөрчлийн тухай хуулийн 12.1 дүгээр зүйлийн 1.11 дэх заалт хэсгийг зөрчсөн үндэслэлээр хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж, 2024 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр зөрчлийн хэрэг нээж 5.000 /таван мянган/ нэгжийн торгууль ногдуулж, нүүж орсон айлуудыг чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтны хугацаатай албан даалгавар хүргүүлсэн. Торгуулийн төлбөрийг барагдуулсан боловч эрх бүхий албан тушаалтны албан даалгаврыг хугацаанд нь биелүүлээгүй тул Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу шүүхийн шийдвэр гүйцэтгэх журмаар албадан биелүүлэх захирамж, гүйцэтгэх хуудас гаргуулахаар 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 01/145 дугаартай албан бичгээр Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд хүргүүлсэн.

Нийслэлийн Засаг даргын 2024 оны “Хууль тогтоомж, хотын стандартыг мөрдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” А/367 дугаар захирамжийн хэрэгжилт:

Нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, иргэдийн эрүүл аюулгүй орчинд ажиллах, амьдрах орчныг бүрдүүлэх зорилгоор төвийн гол магистрал шугам дагуу нийтийн эзэмшлийн зам талбайд холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, норм, стандартын хэрэгжилтийг хангуулах, зөрчлийг газар дээр нь шуурхай арилгуулах 5 дэд ажлын хэсэг байгуулагдаж нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын нийт 130 албан хаагч оролцсоноос тус газрын 25 албан хаагч оролцож, хамтарсан хяналт шалгалтыг зохион байгуулсан. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг газар дээр нь арилгуулах хүрээнд иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад 248 зөвлөмж, 172 мэдэгдэх хуудас, улсын /ахлах/ байцаагчийн 16 албан шаардлага хүргүүлж дараах арга хэмжээ авч ажилласан. Үүнд:


- Барилга угсралтын орчны аюулгүй байдлыг хангуулаагүй нийт 189 зөрчил илрүүлж, 39 байршилд орчны хог хаягдал болон хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангуулж, 43 байршилд барилгын түр хашааг стандартын дагуу солиулав.




- Худалдаа, үйлчилгээний байгууллагуудын гадна хаягийн стандарт хангуулаагүй, өнгө үзэмжгүй нийт 389 зөрчил илрүүлж, 203 газрын гадна хаягийг албадан буулгуулав.



- Нийтийн эзэмшлийн зам талбайн ил задгай холболттой нийт 399 гэрэлтүүлгийн шонг тагжуулж, 27 шонг тэгшлүүлж, 4370 метр сип кабелийг цэгцэлж, 204 шонг будаж өнгө үзэмжийн сэргээж, 2376 метр шилэн кабель буулгаж цэгцлүүлэв.



- Нийслэлийн хэмжээнд шатахуун, шингэрүүлсэн шатдаг хийн худалдаа эрхэлдэг 42 аж ахуйн нэгжийн 284 ШТС, 57 АХЦС-ын гадна орчны өнгө үзэмжийг сайжруулах талаар мэдэгдэл хүргүүлж, 94 ШТС, 16 АХЦС-ын гадна орчныг цэвэрлүүлэв.



1.3.4. Нийслэлийн Засаг даргын албан даалгаврын хэрэгжилт:

Нийслэлийн Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлж, санхүүгийн сахилга хариуцлагыг баримтлан ажиллах тухай” 03 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг баталж хэрэгжилтийг хангуулан, албан даалгаврын хэрэгжилтийн явцын мэдээллийг 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын асуудал хариуцсан мэргэжилтэн (Б.Аюуш)-д хүргүүлсэн.

Нийслэлийн Засаг даргын 2024 онд гаргасан дараах 2 албан даалгаврын жилийн эцсийн хэрэгжилтийг 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт хүргүүлж тайлагнасан. Үүнд:

1. “Худалдан авах ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилт 100 хувь;
2. “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлж, санхүүгийн сахилга хариуцлагыг баримтлан ажиллах тухай” 03 дугаар албан даалгаврын хэрэгжилт 97 хувь.

1.3.5. Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурал, хуралдааны тэмдэглэлийн хэрэгжилт:

Газрын үндсэн чиг үүргийн хүрээнд Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 06 дугаар хуралдаанд **“Барилгын гадна фасадын чанар стандарт, ашиглалтын өнөөгийн байдал”**-ын талаар танилцуулсан. Хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын дагуу газрын даргаас 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр хяналт шалгалтын удирдамж баталж, Нийслэлийн Онцгой байдлын газартай хамтран барилгын гадна фасад, дулаан тусгаарлах материал /хөөсөн полистрол хавтан/ үйлдвэрлэгч 48 аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг зохион байгуулсан. Барилгын материалын салбарт мөрдөгдөж буй норм ба дүрэм, стандартыг мөрдүүлэх талаар улсын байцаагчийн зөвлөмж хүргүүлж, тусгай зөвшөөрөлгүй, тохирлын гэрчилгээгүй үйл ажиллагаа явуулж байсан 13 аж ахуйн нэгж, байгууллагад албан даалгавар хүргүүлж Зөрчлийн тухай хуулийн дагуу 60.0 сая төгрөгийн торгууль ногдуулав.

Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлж, биелэлтийг тухай бүр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт хүргүүлж тайлагнасан. Үүнд:

➤ Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 19 хуралдааны тэмдэглэлээр өгсөн 1 үүрэг даалгавар, 20 дугаар хуралдааны тэмдэглэлээр өгсөн 2 үүрэг даалгавар, 2024 оны 06 дугаар хуралдааны тэмдэглэлээр өгсөн 3 үүрэг даалгавар, нийт 6 үүрэг даалгаврын биелэлт 68.3 хувийн хэрэгжилттэй 2024 оны 06 дугаар сарын 21-ний өдөр;

➤ Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 01 дүгээр хуралдааны тэмдэглэлээр өгсөн 6 үүрэг даалгавар, 04 дүгээр хуралдааны тэмдэглэлээр өгсөн 1 үүрэг даалгавар, 06 дугаар хуралдааны тэмдэглэлээр өгсөн 4 үүрэг даалгавар, нийт 11 үүрэг даалгаврын биелэлт 71.8 хувийн хэрэгжилттэй 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдөр тус тус хүргүүлсэн.

1.3.6. Нийслэлийн удирдлага, газрын удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт:

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн 22 удаа хуралдаж, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаас тус газарт нийт 93 үүрэг даалгавар өгөгдсөнийг тухай бүр хэрэгжилтийг бүрэн хангаж, биелэлтийг ERP-Хяналт шинжилгээ үнэлгээ дэд системээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт тайлагнаж ажилласан.

Хүснэгтээр үзүүлбэл:

Он	Шуурхай хуралдааны тоо	Үүрэг даалгаврын тоо:		Биелэлтийн дундаж
		Нийт:	Байгууллагад өгсөн	
2023	35	543	188 (Үндсэн хэрэгжүүлэх-59)	81.7 хувь
2024	22	587	93 (Үндсэн хэрэгжүүлэх-36)	88.6 хувь

Нийслэлийн Засаг даргаас өгсөн шуурхай үүргийн дагуу барилга угсралт, авто зам, замын байгууламжийн чиглэлээр зөрчил гаргаж буй байршлуудад хяналт шалгалт хийж, холбогдох аж ахуйн нэгж, байгууллагуудад хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ тооцож, танилцуулга мэдээллийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тухай бүр хүргүүлсэн.

Газрын даргын зөвлөлийн хурал: Нийслэлийн Хяналт шалгалтын газрын даргын 2024 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн А/50 дугаар тушаалаар Удирдлагын зөвлөлийн

бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан. Хурлаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөг тухай бүр батлуулж, 5 удаагийн хурлыг зохион байгуулж, нийт 46 асуудал хэлэлцэж, 76 үүрэг даалгавар өгөгдөж, үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.

Д/д	Огноо	Хэлэлцсэн асуудал	Үүрэг даалгавар
1	2024 оны 05 дугаар сарын 29	9	13
2	2024 оны 06 дугаар сарын 06	4	4
3	2024 оны 06 дугаар сарын 20	9	22
4	2024 оны 09 дугаар сарын 23	13	21
5	2024 оны 10 дугаар сарын 24	6	12
6	2024 оны 12 дугаар сарын 16	5	4
Нийт:		46	76

Газрын даргын шуурхай хуралдаан: Шуурхай хуралдааныг нийт 6 удаа (9 дүгээр сараас хойш) зохион байгуулж, нийт 53 үүрэг даалгавар өгөгдөж, биелэлтийг хангуулж ажилласан.

1.4. Нийслэлийн Засаг даргаас Засгийн газрын гишүүд, салбарын сайд нартай байгуулсан хамтран ажиллах гэрээнд заасан зорилтуудын хэрэгжилт, үр дүн, тайлагнасан байдал

Газрын даргын 2024 оны “Гэрээний хэрэгжилтийг хангуулах тухай” А/07 дугаар тушаалаар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч 2024 онд салбар яамдын сайд нартай Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хэрэгжилтийг хангуулах арга хэмжээний төлөвлөгөө баталж, улирал тутам газрын даргын зөвлөлийн хуралд явцыг танилцуулсан. Сайдтай байгуулсан гэрээний хэрэгжилтийн тайланг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлж, хугацаанд нь тайлагнав.

Хүснэгтээр үзүүлбэл:

Д/д	Салбар яамдын сайд	Заалтын тоо	Биелэлтийн хувь:	
			Эхний хагас жилд	Жилийн эцэст
1.	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд	16	93.8%	98.7%
2.	Эрчим хүчний сайд	6	96.6%	96.6%
3.	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд	3	-	100%
4.	Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд	2	-	100%
Нийт:		27	95.2%	98.8%

2024 оны жилийн эцсийн хэрэгжилтийг тайлагнасан байдал:

Д/д	Гэрээ	Огноо	Бичгийн дугаар	2025 оны гэрээнд тусгах саналын тоо
1.	Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд	11 сарын 25	Цахимаар ERP	3
2.	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд	12 сарын 05	01/996	15
3.	Эрчим хүчний сайд	12 сарын 10	01/1022	6
4.	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд	12 сарын 16	01/1041	-

1.5. Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх чиглэлээр хийсэн ажил, үр дүн

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс ажиллуулах хүсэлтийг 2021 оноос эхлэн төрийн үйлчилгээний нэгдсэн портал www.e-mongolia.mn цахим системээр хүлээн авч байна. Уг үйлчилгээнд Ашиглалтад оруулах хүсэлт, Холбогдох бичиг баримт, Холбоо барих / Хүлээх, Үр дүн зэрэг үе шатууд агуулсан. 2024 онд улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын зээл тусламжаар баригдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс ажиллуулах нийт 1592 хүсэлт ирүүлсэн. Иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн хүсэлтийг ажлын 3-5 хоногт багтаан баримт бичгийн бүрдлийг хянаж, судлан шийдвэрлэж байна.

ХОЁР. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН**2.1. Байгууллагын дүрмээр хүлээсэн үндсэн чиг үүргийн хэрэгжилт****2.1.1. Барилга, дэд бүтцийн салбарын төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх:**

Барилга, дэд бүтцийн салбарын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Хяналт шалгалт хийх нийтлэг журмын дагуу төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх, гүйцэтгэлийн хяналт шалгалтыг холбогдох яамдын салбарын хяналтын газрын удирдамж болон газрын даргын баталсан хяналт шалгалтын удирдамжийн хүрээнд зохион байгуулж, түүний үр дүнд илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээг авч ажиллаж байна.

Д/д	Салбар	Хяналтын чиглэл	Харьяа яамд
1	Барилга	Барилгын техник	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам
2		Хот төлөвлөлт	
3		Өргөх байгууламж	
4		Ус хангамж, ариутгах татуурга	
5		Барилгын материал	
6	Дэд бүтэц	Эрчим хүч (цахилгаан)	Эрчим хүчний яам
7		Эрчим хүч (дулаан)	Зам, тээврийн яам
8		Авто зам	
9		Авто тээвэр	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам
10		Газрын тос, хий	
11		Харилцаа холбоо	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам

Хүснэгт. Хяналт шалгалтын тоон үзүүлэлт /2024 оны жилийн эцсийн байдлаар/

Хяналтын чиглэл	Хяналт шалгалтын төрөл			Өгсөн иргэн, ААНБ-ын тоо						Зөрчил шалган шийдвэрлэх	Торгууль (сая.төг)	Нөхөн төлбөр (сая.төг)
	Төлөвлөгөөт (их, дунд эрсдэлтэй)	Урьдчилан сэргийлэх	Төлөвлөгөөт бус (өргөдөл, гомдол)	Дүгнэлт	Зөвлөмж	Албан шаардлага	Шаардах хуудас	Албан бичиг	Танилцуулга			
Барилга	126	1685	2213	282	57	200	1850	632	15	220	457.1	36.55
Дэд бүтэц	71	154	1018	56	17	145	8	417	7	46	86.6	3.2
Нийт	197	1839	3231	338	74	345	1858	1049	22	266	543.7	39.75
Хяналт шалгалтад хамрагдсан нийт объектын тоо: 5267												



ТӨЛӨВЛӨГӨӨТ ХЯНАЛТ ШАЛГАЛТ

Барилга, дэд бүтцийн салбар чиглэлээр салбарын хяналтын <http://shilenkhyanalт.gov.mn> цахим системд нийт 269 объектын эрсдэлийн үнэлгээг оруулж, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 79 дүгээр тогтоолоор баталсан “Салбарын хяналт шалгалтын төлөвлөгөө”-ний дагуу их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн нийт 197 объектод хяналт шалгалтыг зохион байгуулав.

Д/д	Хяналтын чиглэл	Объектодын тоо	
		Төлөвлөсөн	Гүйцэтгэсэн
1	Хот төлөвлөлт	15	15
2	Барилгын техник	43	43
3	Өргөх байгууламж	29	29
4	Ус хангамж, ариутгах татуурга	9	9
5	Барилгын материал	30	30
6	Эрчим хүч (цахилгаан)	20	20
7	Эрчим хүч (дулаан)	20	20
8	Авто зам	11	11
9	Авто тээвэр	20	20
10	Газрын тос, хий	-	-
11	Харилцаа холбоо	-	-
Нийт:		197	197 (100%)

Эрчим хүчний хяналтын чиглэлээр:

Эрчим хүчний яам Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр баталсан 11/02 дугаартай удирдамжийн дагуу Хяналт шалгалтын газрын эрчим хүчний хяналтын улсын /ахлах/ байцаагчид, боловсролын хяналтын улсын /ахлах/ байцаагч нартай хамтран 2024 оны 02 дугаар сарын 22-ны өдрөөс 04 дүгээр сарын 24-ний өдрүүдэд нийслэлийн хэмжээний нийт 20 сургууль, цэцэрлэгийн гадна болон дотор цахилгаан, дулаан хангамжийн инженерийн шугам сүлжээний ашиглалтын төлөв байдал, аюулгүй найдвартай ажиллагааг хангаж байгаа эсэхэд төлөвлөгөөт хяналт шалгалт хийсэн.

Сонгинохайрхан дүүргийн 105, 124-р сургууль, 117, 170, 55-р цэцэрлэг, Баянгол дүүргийн 47, 13, Оюуны ундраа сургуулиуд, 162, 86, 77, 161, 95, 96-р цэцэрлэг, Баянзүрх дүүргийн 61-р цэцэрлэг, Сүхбаатар дүүргийн 40-р цэцэрлэг, Хан-Уул дүүргийн 15-р сургууль, Чингэлтэй дүүргийн 56-р цэцэрлэг, 17, 49-р сургуулиуд нийт (12 цэцэрлэг, 8 сургууль) 20 объектын насжилт өндөртэй гадна болон дотор цахилгаан, дулаан хангамжийн инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжүүдэд үзлэг шалгалтыг зохион байгуулсан. Шалгалтын явцад нийт 70 гаруй дутагдлыг илрүүлж, 28 дутагдлыг газар дээр нь арилгуулсан. Ашиглалтын үеийн норм, дүрмийн хэрэгжилтийг хангах, аюулгүй ажиллагаа

болон техник ашиглалтын дүрмийг хэрэгжүүлэх, баримт бичгийн бүрдлийг хангаж ажиллах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, улсын ахлах байцаагчийн 11-13-02/052/04 дугаартай 16 заалт бүхий зөвлөмжийг 14 сургууль, цэцэрлэгт хүргүүлсэн. Шалгалтын үр дүнгийн талаар 2024 оны 05 дугаар сарын 28 өдрийн 11-13-02/052/01 дугаартай танилцуулга гарган цаашид авах арга хэмжээний талаар Нийслэлийн Онцгой байдлын газар, Нийслэлийн Боловсролын газарт тус тус албан бичгээр санал хүргүүлэв.

Авто тээврийн хяналтын чиглэлээр:

Газрын даргын баталсан "Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх тухай" 04-13-01/036/05 дугаартай удирдамж болон Нийслэлийн Тээврийн бодлогын газрын даргын баталсан "Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг хангаж байгаа эсэхийг магадлан шалгах ажлын хэсэг байгуулах тухай" А/112 дугаартай тушаалтын дагуу нийтийн тээврийн үйлчилгээний 20 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд шалгалт хийж, "Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах тухай" 101 заалттай улсын байцаагчийн албан шаардлага 18, "Зорчигч тээвэр нэг" ОНӨААТҮГ-т "Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний тээвэрлэлтийн нөхцөл, техникийн шаардлагыг хангасан тухай" 04-13-01/036/187 дугаартай улсын ахлах байцаагчийн дүгнэлт гаргав. "Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын дүнгийн тухай" 04-13-01/036/05 дугаартай танилцуулга гаргав.

Авто зам, замын байгууламжийн хяналтын чиглэлээр:

Зам, Тээврийн хөгжлийн яамны Салбарын хяналтын газрын даргын баталсан 04/19 дугаартай төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай удирдамжаар авто зам, гүүрний 11 төсөл арга хэмжээний зураг төсөл, холбогдох баримт бичиг, барилга угсралтын байдалд шалгалт хийж, шилэн хяналтын цахим системд оруулав.

Хот төлөвлөлтийн хяналтын чиглэлээр:

Барилга, хот байгуулалтын яамны Салбарын хяналтын ерөнхий байцаагчийн 2024 оны "Төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай" 09 дугаартай удирдамжийн хүрээнд хот байгуулалтын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй 15 иргэн, хуулийн этгээдэд хяналт шалгалт хийж, бага эрсдэлтэй үнэлэгдсэн тул улсын ахлах байцаагчийн зөвлөмж хүргүүлэв.

Барилгын техникийн хяналтын чиглэлээр:

Барилга, хот байгуулалтын яамны Салбарын хяналтын ерөнхий байцаагчийн 2024 оны "Төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай" 09 дугаартай удирдамжийн хүрээнд барилгын техникийн хяналтын чиглэлээр чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй 43 иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг зохион байшуулж, их эрсдэлтэй үнэлэгдсэн 4 аж ахуйн нэгжид 35.0 сая төгрөгийн торгууль ногдуулж, 39 бага эрсдэлтэй үнэлэгдсэн тул улсын ахлах байцаагчийн зөвлөмж хүргүүлэв.

Ус хангамж, ариутгах татуургын хяналтын чиглэлээр:

Барилга, хот байгуулалтын яамны Салбарын хяналтын ерөнхий байцаагчийн 2024 оны "Төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай" 09 дугаартай удирдамжийн хүрээнд усан хангамж, ариутгах татуургын хяналтын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй 9 иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг зохион байгуулж, бага эрсдэлтэй үнэлэгдсэн тул улсын ахлах байцаагчийн зөвлөмж хүргүүлэв.

Өргөх байгууламжийн хяналтын чиглэлээр:

Барилга, хот байгуулалтын яамны Салбарын хяналтын ерөнхий байцаагчийн 2024 оны “Төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай” 09 дугаартай удирдамжийн хүрээнд өргөх байгууламжийн хяналтын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй 29 иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг зохион байгуулж, их эрсдэлтэй үнэлэгдсэн 2 аж ахуйн нэгжид Зөрчлийн тухай хуулийн 5.15 дугаар зүйлийн 1.3 дахь заалтын дагуу торгуулийн арга хэмжээ авч, зөрчлийг арилгуулах эрх бүхий албан тушаалтны албан даалгавар хүргүүлж, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 6 аж ахуйн нэгжид дутагдал арилгуулах тухай албан шаардлага хүргүүлж, гүйцэтгэлийн хяналт шалгалтаар 1 аж ахуйн нэгжид Зөрчлийн тухай хуулийн 15.2 дугаар зүйлийн 1.2 дахь хэсэгт заасны дагуу арга хэмжээ авч, эрх бүхий албан тушаалтны албан даалгавар хүргүүлж, бага эрсдэлтэй үнэлэгдсэн 21 аж ахуйн нэгж байгууллагад хууль, стандарт, норм дүрмийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар улсын байцаагчийн зөвлөмж хүргүүлэв.

Барилгын материалын хяналтын чиглэлээр:

Барилга, хот байгуулалтын яамны Салбарын хяналтын ерөнхий байцаагчийн 2024 оны “Төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай” 09 дугаартай удирдамжийн хүрээнд барилгын материалын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй 30 иргэн, хуулийн этгээдэд хяналт шалгалтын мэдэгдлийг хүргүүлж, 100 хувийг хамруулсан ба их эрсдэлтэй үнэлэгдсэн 1 ААНБ-д 5.0 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 2 ААНБ-уудад улсын байцаагчийн хугацаатай албан шаардлага гаргаж, бага эрсдэлтэй үнэлэгдсэн ААНБ-уудад улсын ахлах байцаагчийн зөвлөмж хүргүүлэв.

УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХЯНАЛТ ШАЛГАЛТ

Төлөвлөгөөт, төлөвлөгөөт бусаар 10 сэдвийн хүрээнд 1839 объектод урьдчилан сэргийлэх шалгалт хийсэн.

Д/д	Хяналтын чиглэл	Объектодын тоо	
		Төлөвлөсөн	Гүйцэтгэсэн
1	Хот төлөвлөлт	127	127
2	Барилгын техник	420	420
3	Өргөх байгууламж	368	368
4	Ус хангамж, ариутгах татуурга	335	335
5	Барилгын материал	435	435
6	Эрчим хүч (цахилгаан)	6	6
7	Эрчим хүч (дулаан)	3	3
8	Авто зам	10	15
9	Авто тээвэр	30	30
10	Газрын тос, хий	100	100
11	Харилцаа холбоо	2	0
Нийт:			1839

Хот төлөвлөлтийн хяналтын чиглэлээр:

Урьдчилан сэргийлэх шалгалтын хүрээнд нийслэлийн төвийн 6 дүүргийн 127 байршилд хяналт шалгалт хийж, 1568 зөрчил илрүүлж, 158 шаардах хуудас, 16 мэдэгдэх хуудас, 21 улсын /ахлах/ байцаагчийн албан шаардлага, 105 дүгнэлт, 45 иргэн, хуулийн этгээдэд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг явуулж, 24 иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоосон.

Авто тээврийн хяналтын чиглэлээр:

Зам, тээврийн яамны Салбарын ерөнхий байцаагчийн баталсан “Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” 04/02 дугаартай удирдамжийн дагуу кузов засварын үйлчилгээ эрхэлдэг 5 аж ахуйн нэгж, 26 иргэний үйл ажиллагаанд шалгалт хийж, Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах тухай 351 заалт бүхий 30 албан шаардлага гаргаж, 4 аж ахуйн нэгжид 2 сая төгрөгийн торгууль ногдуулж, барагдуулав. Шалгалтын дүнгийн тухай 04-13-01/036/03 дугаартай танилцуулга бичиж, газрын удирдлагуудад танилцуулсан. Нийслэлийн нутаг дэвсгэрт авто үйлчилгээ эрхлэгчдийн судалгааг нэгтгэн гаргасан. Нийт 1116 аж ахуйн нэгж, иргэн авто үйлчилгээ эрхэлж байна.

Эрчим хүчний хяналтын чиглэлээр:

Улс, нийслэлийн төсвийн хөрөнгөөр хийгдэж буй Бичил хорооллыг хангах 2ф400 мм дулааны шугам шинээр татах багц-2 ажил, Төмөр замын 2 дугаар анги орчмын халаалтын зуухтай газруудыг хангах 2ф400 мм-ийн шугамаас үргэлжлүүлэн Улиастайн гүүр хүртэл татах 1.8км дулааны шугамын ажилд хяналт шалгалт хийж, илэрсэн дутагдлыг арилгуулахаар 8 заалт бүхий улсын байцаагчийн 3 албан шаардлага хүргүүлж, биелэлтэд нь гүйцэтгэлийн хяналт шалгалт хийв.

Автозамын хяналтын чиглэлээр:

Зам, Тээврийн хөгжлийн яамны Салбарын хяналтын газрын даргын баталсан “Урьдчилан сэргийлэх шалгалт хийх тухай” 04/04 дугаартай удирдамжийн хүрээнд улс, нийслэл, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэж буй 15 авто зам, замын байгууламжийн угсралт, шинэчлэлтийн байдалд шалгалт хийж, улсын байцаагчийн 1 акт, 8 албан шаардлага, 2 дүгнэлт гаргаж, 1 зөрчлийн хэрэг, хялбаршуулсан журмаар 2 аж ахуйн нэгжид 10 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ ногдуулж, 2 албан даалгавар хүргүүлэв. Хяналт шалгалтаас дурдвал:

- Хан-Уул дүүргийн Чингисийн өргөн чөлөөний авто замын засвар шинэчлэлт (Энхтайвны гүүр-Тэмээтэй хөшөө) хүртэлх авто замын шинэчлэлтийн ажлыг шалгаж, асфальт бетон хучилтын түвшин алдаж, тэгш бус болсон зөрчилд Зөрчлийн тухай хуулийн 14.5 дугаар зүйлийн 7 дах заалтын дагуу 5,000,000 төгрөгийн торгууль ногдуулж, зөрчлийг арилгах хугацаатай албан даалгавар хүргүүлэв.
- Баянзүрх дүүргийн 8, 38 дугаар хороо, авто замын засвар шинэчлэлтийн ажилд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, авто зам, замын байгууламжийн барилга угсралтын ажлыг батлагдсан зураг төсөл, техник технологийн хяналтгүй гүйцэтгэсэн зөрчлийг илрүүлж, улсын байцаагчийн 04-13-02/040-04 дугаартай актаар ажлыг зогсоосон.
- Баянгол, Сонгинохайрхан, Хан-Уул, Сүхбаатар дүүргүүдэд хийгдэж буй төмөр зам, авто зам, нүхэн гарцын барилгын ажлын зураг төсөл, барилга угсралтын байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар улсын байцаагчийн 4 албан шаардлага, 2 дүгнэлт гаргаж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллагаагүй 2 аж ахуйн нэгжид 10.0 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан.
- Хотын стандартын дагуу орчны аюулгүй байдлын хяналт, шалгалтыг сайжруулж, иргэдийн амьдрах орчны эрсдэлийг бууруулах арга хэмжээг авто зам, замын байгууламжийн ашиглалтын байдалд хяналт шалгалт хийж, улсын байцаагчийн 3 албан шаардлага, 1 аж ахуйн нэгжид 5,0 сая төгрөгийн торгууль, 1 албан даалгавар хүргүүлж, биелэлтийг хангуулав.


Удирдах байгууллага, албан тушаалтнаас өгөгдсөн цаг үеийн асуудлаар өгсөн үүрэг даалгаврын дагуу хяналт шалгалт хийх хүрээнд:

1. Хяналт шалгалтын газрын даргын баталсан 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн "Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай" 02-13-01/023/01 дугаартай удирдамжийн хүрээнд:

Нийслэлийн хэмжээнд иргэд оршин суугчдад эрүүл аюулгүй орчин бүрдүүлэх, хууль тогтоомж, стандарт нормын хэрэгжилтийг хангуулах хүрээнд иргэдээс удаа дараа ирүүлж буй өргөдөл, гомдлыг барагдуулах, барилга угсралтын шатанд гарч буй зөрчил, орчны аюулгүй байдлыг нэгдсэн байдлаар арилгуулах зорилгоор дараах 6 чиглэлээр хяналт шалгалт хийх ажлын хэсэг байгуулагдаж, 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдрөөс 05 дугаар сарын 24-ний өдийн хооронд шалгалтын ажлыг хийж гүйцэтгэсэн.

- ✓ Иргэдээс удаа дараа ирүүлж буй өргөдөл гомдлыг барагдуулах, орчны аюулгүй байдлыг нэгдсэн байдлаар хангуулах;
- ✓ Барилга, байгууламж, шугам сүлжээний төлөвлөлт нь АТД, загвар зурагтай нийцэж буй эсэх;
- ✓ Нийтийн эзэмшлийн зам талбайд тулгаж, эвдэж баригдсан зөвшөөрөлгүй барилга, барилгын хийцлэл /пандус, шат/-ийг буулгах;
- ✓ Авто зогсоол хүрэлцэхгүй байгаа Төрийн болон олон нийтийн барилгуудын зогсоолыг нэмэгдүүлэх;
- ✓ Нийслэлийн хэмжээний ШТС, АХЦС-уудын ариун цэврийн байгууламжийг стандартад нийцүүлэх;
- ✓ Тээврийн товчоонуудад хяналт шалгалт хийж, тээвэрлэлтийн нөхцөл хангаагүй, бүтээлэг, татлагагүй том оврын тээврийн хэрэгслийг постоор нэвтрүүлэхгүй байх.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд нийт 53 албан хаагч ажилласнаас Хяналт шалгалтын газраас 34, Хот байгуулалт, хотын стандартын газраас 6, Цагдаагийн удирдах газраас 6, дүүргүүдийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсээс 7 албан хаагч ажиллаж, холбогдох арга хэмжээ авч ажиллав.



Барилга угсралтын ажил гүйцэтгэж буй нийт 227 иргэн, ААНБ-уудын үйл ажиллагаанд хяналт тавьж барилгын түр хашааг стандартад нийцүүлэх, орчны аюулгүй байдлыг хангуулах, барилгын хог хаягдлыг цэвэрлэж ачуулах, ХАБЭА-ын шаардлагыг хангуулах талаар хугацаатай үүрэг даалгавар өгч ажилласан. Шалгалтаар нийт 442 зөрчил илрүүлж, 158 шаардах хуудас, 16 мэдэгдэх хуудас, 16 улсын /ахлах/ байцаагчийн албан шаардлага, 35 иргэн, хуулийн этгээдэд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг явуулж, 24 иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоосон.



Шалгалтын явцад буулгах барилга 25, нийтийн эзэмшилд шилжүүлэх шаардлагатай нийт 38 байршлын судалгааг гаргав. Нийтийн эзэмшлийн зам талбайд хууль тогтоомж, стандарт норм зөрчсөн зөрчлийн судалгааг 2024 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 01/302 дугаар албан бичгээр Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд хүргүүлсэн.

2. Нийслэлийн хэмжээнд шатахуун, шингэрүүлсэн шатдаг хийн худалдаа эрхлэгч 42 аж ахуйн нэгж байгууллагад “Нийтийн бие засах газрын төлөвлөлт байгуулалтад тавих техникийн шаардлага”-ын дагуу нийтийн бие засах газрыг шинэчлүүлэх тухай 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 01/546 дугаар албан бичгээр улсын байцаагчийн мэдэгдэл хүргүүлж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллав.



3. Улаанбаатар хот орчмын “Таван толгой”, “Түргэний гол”, “Хоолт”, “Городок”, “Хонхор”, “Гүнт”, “Баруунтуруун”, “Эмээлт” зэрэг нийт 8 шалган нэвтрүүлэх товчоод дээр барилгын материал, хог хаягдал тээвэрлэж буй автотээврийн хэрэгслүүдийн техникийн шаардлага, тээвэрлэлтийн нөхцөл хангасан байдалд хяналт шалгалт хийсэн.



Товчоодоор нэвтэрч буй авто тээврийн бүх жин стандартаар зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтэрсэн эсэх, барилгын материал, хог хаягдал тээвэрлэж буй тээвэрлэгч жолооч нар элс, хайрга, дайргыг асгарах, гээгдэх, нурахаас хамгаалан зориулалтын бүтээлэг, хашлага, өндөрлөгөө, татлага хэрэглэж буй байдалд шалгалт хийхэд дараах зөрчил дутагдал илэрч байна. Үүнд:

- Тээвэрлэлтийн даац хэтрүүлсэн, даац шалгадаг пүү эвдэрсэн;
- Барилгын материал тээвэрлэлтийн нөхцөл, аюулгүй байдлыг хангаагүй;
- Элс, хайрга, дайрга болон барилгын хог хаягдлыг бүтээлэггүй тээвэрлэх;
- Зориулалтын бус, тоос шороо ихтэй, тээврийн хэрэгслээр тээвэрлэлт гүйцэтгэх;
- Авто замын эвдрэл гэмтэл их;
- “Хоолт”, “Баруун туруун” товчоодын автотээврийн хэрэгсэл нэвтрэх хэсгийн автозамууд эвдэрсэн;
- “Түргэний гол”, “Баруун туруун” товчоодын автотээврийн хэрэгслийн бүх жинг шалгадаг пүү эвдэрсэн, “Хоолт” товчоон дээр шинээр суурилуулсан пүүг ашиглалтад оруулаагүй.

Цагдаагийн Ерөнхий газрын Тээврийн цагдаагийн алба болон Нийслэлийн Нийтийн тээврийн газарт “Иргэдэд ая тухтай орчныг бүрдүүлэх тухай” мэдэгдэл хүргүүлсэн. “Монголын үндэсний бетон үйлдвэрлэгчдийн холбоо” ТББ, “Элс, хайрга, дайрга үйлдвэрлэгч компаниудын холбоо” ТББ-уудад барилгын материал тээвэрлэлтийн нөхцөл, аюулгүй байдал, техникийн шаардлагыг хангаж ажиллах тухай автозамын ажлын захиалагч, гүйцэтгэгч иргэн, аж ахуйн нэгжид улсын байцаагчийн зөвлөмж хүргүүлэв.

2. Хяналт шалгалтын газрын даргын баталсан 2024 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн “Улс, нийслэлийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй барилга байгууламж, орчны аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” 02-13-01/023/03 дугаартай удирдамжийн хүрээнд:

Улс, нийслэлийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа нийт 22 байгууламжид урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг 2024 оны 08 дугаар сарын 15-ны өдрөөс 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийг хүртэл зохион байгуулсан. Үүнд:

- Сургуулийн барилга: 12
- Цэцэрлэгийн барилга: 9
- Хорооны барилга: 1

Ашиглалтад орсон: 4

№	Дүүрэг, хороо	Төсөл, арга хэмжээний нэр	Гүйцэтгэгч компани	Ажлын гүйцэтгэл		
				Зориулалт	Барилга угсралт эхэлсэн он	Хяналт шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдал, Барилга угсралтын явц
1	БГД, 21	Цэцэрлэгийн барилга, 50 ор	Тотал идеал ХХК	Цэцэрлэгийн барилга	2023 онд	Барилга угсралтын ажил бүрэн дуусаж 2024 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн БА-105/2024 дугаартай улсын комиссын дүгнэлтээр байнгын ашиглалтад орсон ба 2 давхар бүхий цэцэрлэгийн зориулалттай барилга байгууламж байна. Одоогийн байдлаар ашиглах явцад алдаа дутагдал илрээгүй.
2	БГД, 9	Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй хорооны цогцолбор барилга	Эй ди констракшн ХХК	Хорооны барилга	2021 онд	Барилга угсралтын ажил бүрэн дуусаж 2024 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр Улсын комисс ажилласан ба акт баталгаажих шатанд явж байгаа болно. Тус барилга нь 4 давхар зоорь бүхий үйлчилгээ конторын барилга.
3	БЗД, 12	Цэцэрлэгийн барилга, 240 ор	Бат хэрэйд ХХК	Цэцэрлэгийн барилга	Барилга дууссан	Тус цэцэрлэгийн барилгын угсралтын ажил дууссан. 2024 оны 05 дугаар сард Улсын комисс хүлээж авсан, 2024 оны 09 дүгээр сараас үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн байна.

4	СБД, 10	Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, 200 ор (243 дугаар цэцэрлэг)	Ванхүү ХХК	Цэцэрлэгийн барилга	2023.05 сар	Барилга угсралтын ажил бүрэн дуусаж 2024.04.24-ны өдрийн БА-090/2024 дугаартай улсын комисс дүгнэлтээр байнгын ашиглалтад орсон байна. Биеийн тамирын заал, 2 давхрын хүзүүвч хэсгийн залгаас, 1,2,3,4,5 дугаартай ангиудад дээврээс ус гоожсон, ханын шавардлага цуурсан байдалтай. Мөн 1 дүгээр давхрын гал тогооны өрөөний хаалга жижиг төлөвлөгдсөн учир гал тогооны тоног төхөөрөмжүүд орох боломжгүй болсон тул цэцэрлэгийн зүгээс хаалгыг томсгож зүссэн байна. Мөн гал тогооны 380В цахилгааны кабелийг тоног төхөөрөмжид залгахад хүндрэл гарсан байна.
---	---------	---	------------	---------------------	-------------	--

Барилга угсралтын ажил хэвийн: 12

№	Дүүрэг, хороо	Төсөл, арга хэмжээний нэр	Гүйцэтгэгч компани	Ажлын гүйцэтгэл		
				Зориулалт	Барилга угсралт эхэлсэн он	Хяналт шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдал, Барилга угсралтын явц
1	БГД, 9	Цэцэрлэгийн барилга, 50 ор /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 9 дүгээр хороо, Өргөө цэцэрлэг/	Интел хайтек ХХК	цэцэрлэгийн барилга	2022 онд	Барилга угсралтын ажил 90 хувьтай байгаа бөгөөд гадна тохижилтын ажил бүрэн дуусаагүй, дотор заслын ажил хийгдсэн, цэвэрлэгээ хийгдээгүй, барилгын гадна фасад болон хаяавч, галын аврах орц гарц бүрэн дуусаагүй, 2 цонх хагарсан, тоноглол бүрэн суугдаагүй байдалтай байна. Уг барилга нь 2 давхар бүхий цэцэрлэг болно.
2	СБД, 12	Сургуулийн барилга, 720 суудалтай	Дарцагт ноёд групп ХХК	720 суудалтай сургуулийн барилга	2021.04 сар	Барилга угсралтын ажил дууссан, дотор засал, цахилгаан, шугам сүлжээний ажил хийгдэж байна. Барилгын талбайд холбогдох зураг төсөл байхгүй тул шалгуулахыг шаардав.
3	СХД, 20	Сургуулийн барилга, 480 суудалтай	Жинст цамхаг ХХК	Сургуулийн барилга		Барилга угсралтын ажил 90%-ийн гүйцэтгэлтэй. Барилгын дотор заслын ажил, гадна тохижилтын ажил, дотор цахилгаан болон сантехникийн ажил хийгдэж байна.
4	БЗД, 24	Цэцэрлэгийн барилга, 240 ор	Манабаганат ХХК /рд5396263/ Хаяг 13 дугаар хороолол ногоон төгөл 77-3 тоот	200 ортой цэцэрлэг	2024 онд	Суурийн цутгамал ханын х1-х5 /у1-у5/ тэнхлэгийн хэв хашмал, арматурчлал хийгдсэн. 2024 оны төсөвт суугдсан суурийн ажил бүрэн хийгдэж дууссан. Нэмэлт санхүүжилт авахаар хүсэлт өгсөн байгаа. Нийслэлийн хөрөнгө оруулалтын газрын хяналтын инженер В.Мөнхзаяа газар дээр нь 3-н удаа хяналт шалгалт хийсэн. Зураг төсөл өөрчлөгдөөгүй. Зоорьтой 2 давхар барилга.
5	БЗД, 5	Цэцэрлэгийн барилга, 240 ор	Гурванбулаг код ХХК /рд5156866/ СБД 9 дүгээр хороо Шинэ дэлхий цамхаг 7-701 тоот	240 ортой цэцэрлэг /52 дугаар цэцэрлэг/	2022 онд	Нийслэлийн засаг даргын 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн А/766 дугаар шийдвэрээр Баянзүрх дүүргийн 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт 1330700210 нэгж талбарын дугаартай 2 давхар зоорьтой цэцэрлэгийн барилга./52 дугаар цэцэрлэгийн барилгыг буулгаж барьсан./ Барилгын ажил 63% -тай явагдаж байна.
6	БГД, 11	Сургуулийн барилга, 960 ор	Содон номин констракшн ХХК	Сургуулийн барилга	2023 онд	Барилга угсралтын ажил 92 хувьтай гүйцэтгэж байгаа бөгөөд гадна зам талбай тохижилтын ажил бүрэн дуусаагүй, барилгын дотор заслын ажил хийгдэж дууссан боловч зарим анги танхимын шал хийгдээгүй, ариун цэврийн хэрэгсэл бүрэн суулгаж тоноглоогүй, хаалга бүрэн

						суурилуулаагүй байдалтай байна. Уг барилга нь хуучин байсан барилгыг буулгаж шинээр зорь бүхий 3 давхар, спорт заалтай барилга байгууламж болно.
7	БГД, 10	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор барилга	Шонхорчин ХХК	Сургууль цэцэрлэгийн цогцолбор барилга	2022 онд	Барилга угсралтын ажил 89 хувьтай гүйцэтгэж байгаа бөгөөд төсөвт өртгөөс хэт давсан тул төсвийн дахин тодотгол хийлгэж цааш үргэлжлүүлэх төлөвлөгөөтэй байгаа болно. Мөн барилгын гадна тохижилтын ажил дутуу, ангиудын шал бүрэн дуусаагүй, хаалга бүрэн хийгдээгүй, ариун цэврийн өрөө болон бусад тоноглол хийгдээгүй, байдалтай байна. Уг барилга нь 2 давхар спорт заал бүхий цэцэрлэг сургууль хосолсон цогцолбор барилга юм.
8	СХД, 28	Сургуулийн барилга, 640 суудал /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 28 дугаар хороо/	Бумбод ХХК	Сургуулийн барилга	-	Дотор замаск, дотор цахилгааны монтаж, хийн газны барилгын гадна фасадын шавардлага, дэд өртөөний барилгын суурь, шатны хайс хашлагийн ажлууд хийгдэж байна. Хийн зуухны барилгын гадна фасадын эмүльс, спорт заалны шал, дотор засал, гадна зам талбайн өндөржилт, дэд өртөөний барилгын өрлөгийн ажлууд хийгдэж байна. Дэд өртөөний барилгын гадна шавар, дотор засал, хаалга суулгах, тоноглол суурилуулах ажлууд хийгдэж байна. Хийн зуухны барилгын узелийн ажил хийгдэж байна. Дотор ангиудын паркетан шал, ангиудын будаг, халаах хэрэгсэл суурилуулах, дотор модон хаалга суулгах, гадна тохижилтын ажлууд хийгдэж байна.
9	БГД, 11	Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, 150 ор (Баянгол дүүрэг, 11 дүгээр хороо, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн цэцэрлэг)	Тэргүүн констракшн ХХК	Цэцэрлэгийн барилга	2023.05.01	Дотор заслын ажил болох ханын шаврын ажил, дотор цахилгааны ажил, дотор шугамын ажил хийгдэж байна.
10	БЗД, 26	Сургуулийн барилга, 640 суудал, спорт заал /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 26 дугаар хороо, Олимп хотхон/	Голден лайт групп ХХК	Сургуулийн барилга	2023	Дам нурууны арматур бөөж, хучилтын арматур боолт хийгдэж байна. Суурь болон зоорийн давхрын дулаалгын ажил хийгдсэн.3-р давхрын угсралтын ажил хийгдэж дууссан. Цонх суулгах ажил, дотор өрлөгийн ажил дууссан бөгөөд дотор засал шаврын ажил, гадна фасад угсралтын ажил хийгдэж байна.
11	СБД, 11	Тусгай хэрэгцээт 29 дүгээр сургууль, дотуур байрны их засварын ажил (Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг)	Гурван тахилгат оргил ХХК	Сургуулийн барилга		Сургуулийн барилгын 1,2 дугаар давхрын цонх солигдсон, 1,2,3 дугаар давхрын хана болон таазны замаск 2 үе татагдаж зүлгүүрийн ажил хийгдсэн. 2,3 дугаар давхрын коридорын дүүжин таазны ажил хийгдсэн. 1,2 дугаар давхрын шалны бетон цутгалтын ажил хийгдсэн. Цахилгааны ажил дууссан. Эрэгтэй дотуур байрны хана таазны заслын ажил хийгдэж байна. Эрэгтэй дотуур байрны гадна фасадын өнгө сэргээлтийн ажил хийгдэж байна.
12	ХУД, 16	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор (Хан-Уул дүүрэг, 16 дугаар хороо)	ЗМК Глобал ХХК	Цэцэрлэгийн барилга	2023	Дээврийн налуулга, бетон цутгалтын ажил хийгдэж дууссан. дотор шугам сүлжээний ажил хийгдэж байна. Дотор ханын шавардлагын ажил хийгдэж байна.

Барилга угсралтын ажил зогссон: 6

№	Дүүрэг, хороо	Төсөл, арга хэмжээний нэр	Гүйцэтгэгч компани	Ажлын гүйцэтгэл		
				Зориулалт	Барилга угсралт эхэлсэн он	Хяналт шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдал, Барилга угсралтын явц
1	БЗД, 12	Сургуулийн барилга, 640 ортой	Жинсийн орой ХХК	Сургуулийн барилга	Эхлээгүй	Нийслэлийн 20-р цэцэрлэгийн өргөтгөлийн ажил газар чөлөөлтийн ажил дээр гацсан. Газар шорооны ажил эхлээгүй байна. Өргөтгөлийн дэд бүтцийн зөвшөөрөл гарч зураг батлагдсан байдалтай байна.
2	СХД, 22	Цэцэрлэгийн барилга, 200 ортой	Татах хүч ХХК	Цэцэрлэгийн барилга	2019	Барилга угсралтын ажил 88%-ийн гүйцэтгэлтэй. Барилгын дотор заслын ажил, гадна тохижилтын ажил, дотор цахилгаан болон сантехникийн тоноглолын ажил хийгдэх дутуу. Барилга угсралтын ажил зогссон.
3	БЗД, 14	Сургуулийн барилга, 640 ортой	Цамхаг констракшн ХХК	Сургуулийн барилга	2023	Тус барилга нь 2 блок байх бөгөөд нэгдүгээр блокийн каркас угсралтын ажил дууссан, 2 дугаар блокийн бетон цутгамал 80%-тай байна. Цутгалт хийх үедээ нягтруулалт дутуу хийгдсэний улмаас хамгаалалтын үе ил гарах, мөн түүгээр нь арматур зэврэх зэрэг дутагдлууд илэрсэн. Тус сургуулийн барилгын дуусах хугацаа 2025 он хүртэл хойшилсон гэх тайлбар өгсөн.
4	СХД, 31	Сургуулийн барилга, 320 суудалтай	Глобал рост ХХК	Сургуулийн барилга	2019.07.18	Барилга угсралтын ажил 86%-ийн гүйцэтгэлтэй. Барилгын дотор хаалга угсралт, гадна тохижилтын ажил, дотор цахилгаан болон сантехникийн тоноглолын ажил хийгдэх дутуу. Барилга угсралтын ажил зогссон.
5	ЧД, 8	Сургуулийн барилга 640 суудал /ЧД, 8 дугаар хороо/	Лакилайф ХХК	Сургуулийн барилга	2024	Барилга угсралтын суурийн ажил хийгдэж байна. Суурийн арматурчлал хийгдэж бетон цутгалт хийгдсэн. Суурийн нүх шороогоор дүүргэж, нягтруулалт хийгдэж байна.
6	СБД, 16	Сургуулийн барилга, 320 суудалтай	Агардүнз ХХК, Сэхүүн чоно ХХК-ийн түншлэл	320 суудалтай сургуулийн барилга,	2019.12.26	Барилгын ажил хийхгүй удаашруулсан шалтгаанаар Захиалагч Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар болон гүйцэтгэгч Агардүнз ХХК, Сэхүүн чоно ХХК-ийн түншлэлийн хооронд 2 удаагийн шүүх хуралдаан болж, Анхан шатны шүүхийн шийдвэр 2024.05.14-ний өдөр гарсан нь Агар дүнз ХХК-ийн талд шийдэгдсэн. Нийслэлийн хөрөнгө оруулалтын газраас гомдол гаргаж Нийслэлийн дээд шатны шүүх хурал 2024.08.20-ны өдөр болж Нийслэлийн хөрөнгө оруулалтын газрын талд шийдвэр гарч барилгын ажил зогссон байна.

Барилга угсралтын явцад дараах зөрчил дутагдлууд түгээмэл илэрч байна. Үүнд:

- Бетон цутгах үедээ доргиур хангалтгүй тавьснаас бетон хольц ялгарч бетоны бат бэх чанар алдагдсан;
- Барилгажилтын талбайд арматурыг хур тунадас, ус чийгээс хамгаалах хадгалалтын горимыг мөрддөггүй;
- Барилгын анхны зураг төслийг өөрчилсөн;
- Нэмэлт хаалга, хаалт гаргасан;
- Цонхны нээлхий хэсэг онгойдоггүй;
- Хур тунадасны улмаас үүссэн тогтоол ус барилгын дээвэрт нэвчсэн;
- Барилгын хог хаягдлыг тээвэрлээгүй.



Барилга угсралтын үед гарсан эдгээр дутагдлуудыг арилгуулахаар улсын байцаагчийн 02-13-01/033/06 дугаартай зөвлөмжийг холбогдох аж ахуйн нэгж, байгууллагуудад хүргүүлсэн.

3. Хяналт шалгалтын газрын даргын баталсан 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн "Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай" 02-13-01/024/07 дугаартай удирдамжийн хүрээнд:

Нийслэлийн нийтийн эзэмшлийн авто зам, гудамж талбайд ашиглагдах тусгай зориулалтын бодис, давсны хадгалалт, нөөц, чанар аюулгүй байдал, техник тоног төхөөрөмжийн бэлэн байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт зохион байгуулснаас нийтийн эзэмшлийн авто замын цэвэрлэгээ эрхлэгч 28 (Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар-8, компани-20) аж ахуйн нэгжийн 23 агуулах, 576 машин тоног төхөөрөмж, техник хэрэгсэл хамрагдсан.



Нийтийн эзэмшлийн зам, талбайн цэвэрлэгээний 28 аж ахуйн нэгжүүдэд 17181 м3 багтаамж бүхий 23 агуулах тэдгээрт 7725 тн давс, 6132 тн цас, мөс хайлуулах зориулалтын бодисыг нөөцөлсөн байна. Эдгээр аж ахуйн нэгжүүдэд инженер техникийн ажилтан 94, мастер 64, зам талбайн үйлчлэгч 1015, тээвэрлэгч жолооч 270, ачигч 269, бусад 13 буюу 1783 хүн ажиллаж байна. Нийтийн эдэлбэр газар, хотын гудамж, зам талбайн цэвэрлэгээ эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн тээврийн хэрэгслийн техникийн шаардлага, давс, бодисын нөөц, хадгалалтын байдлыг шалгаж дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

- Нийтийн эдэлбэр газар, хотын гудамж, зам талбайн цэвэрлэгээ эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн удирдлага, инженер техникийн ажилтан, ажиллагсад эрхэлж буй үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, эрх зүйн актуудыг бүрэн судалж, үйл ажиллагаандаа мөрдөж ажилладаггүй, дотоод хяналт шалгалтыг тогтмол хэрэгжүүлдэггүй;
- Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн ажил, үйлчилгээнд ашиглаж буй машин механизм хуучирч, эдэлгээний баталгаат гүйлтийн нөөц багатай болсон,

техникийн найдвартай ажиллагаа алдагдсан, дотоод үйл ажиллагаа зохион байгуулалт хангалтгүй;

- Аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд эрх бүхий байгууллагуудаас тавих хяналт сул байгааг боловсронгуй болгох;
- Хотын гудамж, зам талбайн цэвэрлэгээ эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн машин техникийн техникийн шаардлага, давс, бодисын нөөц, хадгалалтын байдал нь өвөлжилтийн бэлэн байдлыг бүрэн хангаагүй байна.

Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, ажил, үйлчилгээний зохион байгуулалт, үйл ажиллагааг сайжруулах хүрээнд нийтийн эдэлбэр газар, хотын гудамж, зам талбайн цэвэрлэгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагуудад 2024 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 01/889 дугаар албан бичгээр мэдэгдэл хүргүүлж, хувийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Дүүргүүдийн Засаг дарга нарт тус тус хүргүүлэв.

4. Хяналт шалгалтын газрын даргын баталсан 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн "Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай" 06-13-06/019/08 дугаартай удирдамжийн хүрээнд:

Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа нийт 59 ил сав бүхий автомашиныг хийгээр цэнэглэх станц (АХЦС)-уудын шингэрүүлсэн шатдаг хий хадгалах савны суурилуулалт, тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг 2024 оны 11 дүгээр сарын 04-ний өдрөөс 11 дүгээр сарын 08-ны өдрүүдэд зохион байгуулсан. Нийслэлийн нутаг дэвсгэрт шингэрүүлсэн шатдаг хийн хадгалалт, түгээлт, тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг 6 аж ахуйн нэгжийн 5 хий цэнэглэх станц, 2 завсрын агуулах, 59 автомашин хийгээр цэнэглэх станцаас АХЦС-29, ОТТТС-30, 1 байгалийн хийн станц үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт. Аж ахуйн нэгж, байгууллагын судалгаа

№	Аж ахуйн нэгж	Хий цэнэглэх станц	АХЦС		АХЦС нийт	Завсарын агуулах	Тээврийн хэрэгсэл
			Ил савтай	Далд савтай			
1	Дашваанжил ХХК	1	5	10	15	-	22
2	Гор газ ХХК	1	10	3	13	-	22
3	Юнигаз ХХК	1	4	8	12	-	15
4	Синчи Ойл ХХК	1	3	3	6	-	3
5	М1 инженеринг ХХК	1	1	-	1	1	5
6	Сити газ	1	1	-	1	-	-
7	Хийн тулга ХХК	-	-	-	-	1	9
8	Шунхлай трейдинг ХХК	-	6	-	6	-	--
9	Тэс петролиум ХХК	-	5	-	5	-	
Нийт		6	35	24	59	2	76

Шингэрүүлсэн шатдаг хий тээвэрлэгч аж ахуйн нэгжүүдийн өмчлөлд шингэрүүлсэн шатдаг хийн тээврийн 25 автоцистерн, баллонтой шахсан хий тээвэрлэдэг 51 ачааны зориулалттай автомашин бүртгэлтэй байна. Аюултай ачаа тээврийн хэрэгслүүдийн техникийн шаардлага, тээвэрлэлтийн нөхцөл хангасан байдлыг 22 үзүүлэлтээр шалган үнэлгээ өгч, аж ахуйн нэгжүүдийн удирдах болон инженер техникийн ажилтан, ажиллагсад, жолооч нарт мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, илэрсэн зөрчил, дутагдлыг нэн даруй арилгах үүрэг даалгавар өгснөөс дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

- 17 АХЦС-ын түгээр болон саравч, хий дамжуулах шугам хоолойд засвар үйлчилгээ хийлгэсэн.
- 5 АХЦС-ын түгээгчийн байрны засварыг ажлыг хийсэн.
- 10 АХЦС-ын гадна орчны болон зам талбай тохижилтын ажлыг хийлгэж акт, гэрэл зургаар баталгаажуулсан.
- 7 АХЦС-ын аянга зайлуулагчийн эсэргүүцлийг хэмжүүлсэн байна.

Хяналт шалгалтын газрын 2024 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 01/874 дугаар албан бичгээр “Орчны тохижилт, аюулгүй байдлыг хангах мэдэгдэл хүргүүлэх тухай” улсын байцаагчийн мэдэгдлийг нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй нийт 116 иргэд, аж ахуйн нэгж, худалдаа үйлчилгээ эрхлэгчид, СӨХ-дод хүргүүлсэн.

5. Хяналт шалгалтын газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн “Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт тухай” 02-13-01/025/09 дугаартай удирдамжийн хүрээнд:

Нийслэлийн Хяналт шалгалтын газар болон Цагдаагийн Ерөнхий газрын Экологийн цагдаа албаны нийт 60 гаруй албан хаагчид 2024 оны 12 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн 15-100кВт хүртэл, 100кВт-аас дээш хүчин чадалтай уурын болон усан халаалтын зуух ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад зуухны бүрэн бүтэн байдал, агаарт ялгаруулах хаягдал утааны шүүгч суурилуулсан эсэх, ажиллагаа хэвийн эсэх, холбогдох хууль тогтоомжийг зөрчин түүхий нүүрс хэрэглэсэн эсэх, бусад хориглосон шатах материал түлсэн эсэхэд хяналт шалгалт хийсэн. Үүнд:

- 15-100кВт хүртэл хүчин чадалтай нийт 1049 (БЗД-92, ХУД-492, ЧД-147, НД-23, БГД-33, СБД-105, СХД-157) нам даралтын зуух хамрагдсан бөгөөд утааны шүүлтүүргүй, зуухны паспортгүй, бүртгэлжүүлээгүй, утааны хийн хэмжигч суурилуулаагүй зэрэг нийтлэг зөрчлүүд илэрсэн.


- 100 кВт-аас дээш хүчин чадалтай 70 ААНБ-ын 155 халаалтын зуух хамрагдсанаас утааны шүүлтүүртэй 58, утааны шүүлтүүргүй 6, утааны шүүлтүүр ажиллаж байгаа 56, утааны шүүлтүүр ажиллуулаагүй 8, зуухны паспорттой 61, шүүлтүүрийн төрөл хуурай 52, нойтон 10, утааны хийн хэмжигч суурилуулсан 48, утааны хийн хэмжигч суурилуулаагүй 15, хаягдал утааны хэмжилт дүн шаардлага хангасан 27, хаягдал утааны хэмжилтийн дүн хийлгээгүй 35, нүүрсний агуулах задгай 37, нүүрсний агуулах битүү 26, үнсний агуулах задгай 43, үнсний агуулах битүү 20, үйл ажиллагаа явуулаагүй 2, түлшний төрөл шахмал түлш түлж байгаа 16, багануурын баяжуулсан нүүрс 45, газанд холбогдсон 3, мидлинг 4 аж ахуйн нэгж, байгууллага байна.



Уурын болон усан халаалтын зуух ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад холбогдох хууль, дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг хангуулах, эрсдэлээс урьдчилан сэргийлж тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хангуулах тухай 11-13-02/055/70 дугаартай зөвлөмжийг нийт 520 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хүргүүлж, мэргэжил арга зүйн заавар зөвлөмж өгч ажилласан.

6. Хяналт шалгалтын газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн А/68 дугаар тушаалаар баталсан "Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт зохион байгуулах тухай" удирдамжийн хүрээнд:


Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус өмчийн ерөнхий боловсролын 18 сургууль, 18 цэцэрлэгийн гадна орчны аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг зохион байгуулсан. Шалгалтаар явган хүний зам талбай эвдрэлтэй, хашаа хайс стандартын бус эвдрэлтэй, тоглоомын талбай, чийрэгжүүлэх талбайн стандарт хангалтгүй, хог хаягдал цуглуулах цэг битүүмжлэл алдагдсан, гол хаалганы шат, довжоо хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хүртээмжгүй, гэрэлтүүлэг хангалтгүй зэрэг нийтлэг зөрчлүүд илэрсэн. Сургууль, цэцэрлэгийн орчны эрсдэлийг бууруулах, холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг хангуулах талаар зөвлөмж өгч ажиллав.



ТӨЛӨВЛӨГӨӨТ БУС ХЯНАЛТ ШАЛГАЛТ

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудаас ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлт, гомдол, мэдээлэл, холбогдох яамдын Салбарын хяналтын газар болон газрын даргын баталсан нийт 22 удирдамжийн хүрээнд нийт 3231 өргөдөл, гомдол, хүсэлтийн дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулж, хуулийн хугацаанд улсын байцаагчийн эрх зүйн баримт бичиг, албан бичгээр хариуг хүргүүлэн ажилласан.

Өргөдөл, гомдлын ангилал (хувиар)



Өргөдөл, гомдлын ангилал (хувиар)

ДЭД БҮТЦИЙН САЛБАРТ



ГҮЙЦЭТГЭЛИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ

Тайлант хугацаанд барилга, дэд бүтцийн чиглэлээр Улсын (ахлах) байцаагчийн 2656 заалт бүхий 345 албан шаардлага, 256 албан даалгаврыг иргэн аж ахуй нэгжид хүргүүлэн гүйцэтгэлийн хяналт хийж ажилласан. Улсын байцаагчийн албан шаардлага, албан даалгаврын мөрөөр 244 гүйцэтгэлийн хяналт шалгалт хийж, биелэлт 73 хувьтай байгаа ба өгөгдсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй 1 иргэн, 7 аж ахуйн нэгжид 3550.0 мян.төгрөгийн торгууль ногдуулж, барагдуулсан.

Зөрчлийн талаарх гомдол мэдээлэл, шалган шийдвэрлэх ажиллагаа

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн зөрчлийн талаарх гомдол, мэдээллийн нийт 289 (зөрчлийн 244, шилжиж ирсэн 45) бүртгэл хийж, тухай бүр Нийслэлийн Прокурорын газрын niislelprozurchil@gmail.com цахим хаягаар нэгдсэн бүртгэлд хүргүүлсэн. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хуулийн хугацаанд зохион байгуулж дараах шийдвэрийг гаргаж ажиллав. Үүнд:


- Зөрчлийн хэрэг нээж шийдвэрлэсэн- 25;
- Хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн- 241;
- Харьяаллын дагуу шилжүүлсэн- 4;
- Хүлээн авахаас татгалзсан- 19.

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны хүрээнд нийт 750.0 сая төгрөгийн торгууль ногдуулж, 543,700,000 төгрөгийн орлогыг нийслэлийн төсөвт төвлөрүүлээд байна. Гүйцэтгэл 72,4 хувь.

Тандалт судалгааны ажлын хүрээнд:

Монгол Улсын хэмжээнд орон сууцны барилгад ашиглагдаж байгаа нийт 9262 лифт бүртгэлтэй байдгаас орон нутагт 1133 лифт, нийслэлийн хэмжээнд 8129 лифтийг ашиглаж байна. Нийслэлийн хэмжээнд ашиглагдаж байгаа лифтийг насжилтаар нь ангилбал 1-5 хүртэлх жилийн насжилттай 2331, 6-аас 10 хүртэлх жилийн насжилттай 2240, 11-15 хүртэлх жилийн насжилттай 2189, 16-20 хүртэлх жилийн насжилттай 906, 21 ба түүнээс дээш жилийн насжилттай 306, ашиглалтын шаардлага хангахгүй 157 лифт байна. Их эрсдэлтэй 463 лифт, ашиглалтын шаардлага хангахгүй болсон 157 лифтийн судалгааг 2024 оны 10

дугаар сарын 23-ны өдрийн 01/823 дугаар албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэв.



Бүртгэл баталгаажуулалтад хамруулах ажлын хүрээнд:

Аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу Кран-85, Лифт-350, Эскалатор-26, Хүн-Ачаа зөөврийн өргүүр-17, дүүжин өргүүр-86, Авто кран-73, Манипуляторт кран-48, Сагстай өргөгч-14, нийт 691 өргөх байгууламжид хяналт шалгалт хийж улсын бүртгэлд шинэчлэн бүртгэсэн байна. Авто тээврийн үндэсний төвийн Техникийн хяналтын үзлэгийн системд өргөх байгууламжийн тусгай зөвшөөрөлтэй 38 аж ахуйн нэгжийн өөрөө явагч тээврийн хэрэгсэл дээр суурилсан 121 өргөх байгууламжийг бүртгэсэн байна.

Төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг мэдээлэл, сургалт, арга зүйгээр хангах ажлын хүрээнд:

Барилга, дэд бүтцийн салбарт хууль, стандарт, нормыг мөрдүүлэх чиглэлээр 2024 онд 8 удаагийн сэдэвчилсэн сургалтыг зохион байгуулж, нийт 1510 иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг хамруулав.

Д/д	Чиглэл	Сэдэв	Оролцогч -дын тоо
1	Барилга	Барилга байгууламжийн ашиглалт, хотын стандартын хэрэгжилтийг хангуулах тухай	478
2		Барилгын материал үйлдвэрлэгч хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай	84
3	Дэд бүтэц	Инженерийн шугам сүлжээний ашиглалтын үед анхаарах асуудал /дулаан ус хангамж/, Цахилгаан хангамжийн ашиглалтын үеийн аюулгүй ажиллагаа, Шингэрүүлсэн шатдаг хийн баллонт тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагаа	435
4		Шингэрүүлсэн шатдаг хийн баллонт тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа", "220 граммаар савласан шингэрүүлсэн шатдаг хийн ахуйн хэрэглээ	29
5		Шингэрүүлсэн шатдаг хийн ашиглалт, аюулгүй ажиллагаа	38
6		Шингэрүүлсэн шатдаг хийн ашиглалт аюулгүй ажиллагааны талаар	330
7		Даралтат савыг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрмийн хүрээнд аюулгүй ажиллагааг хангаж ажиллах сэдэвт сургалт	86
8		Авто үйлчилгээ эрхлэхэд мөрдөгдөж буй хууль тогтоомжууд, үйл ажиллагааг шалгах хяналтын хуудасны талаарх зөвлөмж	30
Нийт:			1510

2.1.2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг зохион байгуулах

Монгол Улсын Засгийн засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/503 дугаар захирамжийн дагуу барилга байгууламж, түүний гадна талбайн тохижилт, засварлах, тоноглох ажлыг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж, стандартын шаардлагад нийцүүлэн ашиглалтад оруулах үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна.

- Барилга /бага, дунд, өндөр төвөгшилтэй/
- Их засвар, тохижилтын ажил
- Инженерийн барилга байгууламж /цахилгаан, шугам сүлжээ/

Барилгын тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдуулан нийслэлийн хэмжээнд барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагаа зохион байгуулахад шаардагдах бичиг хэрэг, тээвэр шатахуун, харилцаа холбоо, хөгжлийн бэрхшээлтэй иргэний цалин, урамшуулал зэрэг үйл ажиллагааны зардлыг барилга байгууламжийн бага, дунд, өндөр төвөгшлийн ангиллаар тооцож судалгааг хийж, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатараас 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр “Санал хүргүүлэх тухай” 01/135 дугаартай албан бичгээр Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлэв. Тус яамнаас барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын ажиллах зардлын тооцоог барилга байгууламжийн төвөгшил, ангилалтай уялдуулан судалж, санал боловсруулах үүрэг бүхий ажлыг хэсэг байгуулахаар шийдвэрлэж, тус газраас ажлын хэсэгт ажиллах албан тушаалтны мэдээллийг 2024 оны 05 сарын 07-ны өдрийн 01/64 дугаар албан бичгээр Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлэв.

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн барилга, байгууламж, гадна цахилгаан хангамж, барилга байгууламжийн гадна талбайн тохижилт, засварлах, тоноглох ажлыг ашиглалтад оруулах тухай хүсэлтийг www.e-mongolia.mn, www.e-business.mn, www.edoc.ulaanbaatar.mn цахим portalуудаар хүлээн авч ажлын 5-10 хоногт судлан шийдвэрлэж байна. 2024 онд нийт 1592 хүсэлт ирүүлснээс баримт бичгийн бүрдэл дутуу 364 хүсэлтийг татгалзаж, 1217 хүсэлтийг комисс ажиллах хуваарьт оруулан ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг зохион байгуулав.


Д/д	Төрөл	Ирсэн хүсэлт	Комисс ажилласан	Татгалзсан	Дүгнэлт баталгаажсан	Шийдвэрлэлтийн дундаж хугацаа
1	Барилга байгууламж	599	336	211	239	7 хоног
2	Цахилгаан хангамж	723	652	71	456	6 хоног
3	Засвар, тохижилт	270	229	82	145	5 хоног
Нийт:		1592	1217	364	840	6 хоног

Барилга байгууламжийг ашиглалтад оруулахад бэлтгэл ажлыг хангуулах хүрээнд газрын даргын 2024 оны “Удирдамж, арга зүйгээр хангах тухай” А/09 дүгээр тушаалын дагуу барилга, байгууламж, гадна цахилгаан хангамж, барилга байгууламжийн гадна талбайн тохижилт, засварлах, тоноглох барилга байгууламжийн гүйцэтгэлд газар дээр нь урьдчилсан үзлэг хийж, илтгэх хуудсаар газрын даргад танилцуулж, комиссын хуваарьд тусган баталгаажуулж байна.

Комисс ажиллах хуваарийг 7 хоног бүр боловсруулж, комиссын бүрэлдэхүүнд ажиллах гишүүдийн томилгоог газрын даргаар батлуулан байгууллагын цахим хуудас <https://www.inspection.ub.gov.mn/commission>-д байршуулан ажиллаж байна.

2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар батлагдсан хуваарийн дагуу нийт 1209 байршилд барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг зохион байгуулснаас комиссын нийт гишүүдийн санал, дүгнэлтээр **838** барилга байгууламжийг ашиглалтад оруулж, 364 барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах шийдвэр гаргасан.

- Барилга - 264,
- Цахилгаан хангамж - 420,
- Засвар, тохижилт - 154.



Гэр хорооллын дахин төлөвлөлт: Гэр хорооллыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд 46 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг зохион байгуулж, нийт **52** блок, **5911** айлын орон сууцны барилгыг ашиглалтад оруулсан байна. Үүнд:

- Баянзүрх дүүрэгт 25 блок (2816 айл)
- Хан-Уул дүүрэгт 4 блок (403 айл)
- Баянгол дүүрэгт 4 блок (720 айл)
- Сонгинохайрхан дүүрэгт 4 блок (384)
- Сүхбаатар дүүрэгт 15 блок (1588 айл).

Ашиглалтад орсон барилга байгууламжийн мэдээлэл: Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 55 дугаар тушаал, Үндэсний статистикийн хорооны дэд даргын 2021 оны А/01 дүгээр тушаалаар баталсан маягтын дагуу нийслэлийн хэмжээнд ашиглалтад оруулсан барилга байгууламжийн дэлгэрэнгүй мэдээллийг 30-130 талбараар орон зайн мэдээллийн санд бүртгэн, дараах 6 байгууллагад улирал бүр хүргүүлж байна. Үүнд:

- Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам;
- Авлигатай тэмцэх газар;
- Татварын ерөнхий газар;
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газар;
- Барилгын хөгжлийн төв;
- Нийслэлийн Статистикийн газар.

Барилга байгууламжийн орон зайн мэдээллийн сангийн бүртгэл: Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс ажиллаж, дүгнэлт баталгаажсан барилга

байгууламжийн орон зайн мэдээллийг QGIS системийн мэдээллийн санд 6 төрөлт өгөгдлөөр оруулж, 2014 онд нийт 732 объектийн дэлгэрэнгүй мэдээллийг бүртгэн баяжилт хийсэн байна. Үүнд:


- Орон сууцны барилга: 128,
- Олон нийтийн барилга: 108,
- Цахилгаан хангамж: 353,
- Шугам сүлжээ: 9,
- Их засвар, шинэчлэлт: 70,
- Тохижилт: 64.

Мэдээллийн сангийн өгөгдөл, бүртгэсэн барилгын тоо:

№	Төрөл	2023 оны тоон үзүүлэлт		2024 оны тоон үзүүлэлт	
		Барилгын тоо	Баталгаажсан тоо	Барилгын тоо	Баталгаажсан тоо
1	Орон сууцны барилга	94	85	128	128
2	Олон нийтийн барилга	73	69	108	108
3	Цахилгаан хангамж	278	278	353	353
4	Шугам,сүлжээ	16	16	9	9
5	Засвар	79	42	70	70
6	Тохижилт	42	34	64	64
Нийт:		582	524	732	732

Мэдээллийн санд бүртгэсэн төрөл:

№	Төрөл	2023 он	2024 он
1	Үйлчилгээтэй орон сууц	48	69
2	Орон сууц	23	31
3	Аялал жуулчлалын цогцолбор	26	28
4	Сургууль	13	9
5	Цэцэрлэг	12	21
6	Эмнэлэг	2	9
7	ШТС	4	2
8	Үйлчилгээ	11	30
9	Үйлдвэр	5	21
10	Бусад	28	19
Нийт:		173	239



2.2. Газрын үндсэн чиг үүрэгтэй холбогдох хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр хэрэгжүүлсэн ажил, үр дүн

Байгууллагын үйл ажиллагаанд хамаарах хууль тогтоомж, бодлого, шийдвэр, баримт бичгийн төсөлд тусгах саналыг боловсруулан Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, бусад дээд шатны холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.

№	Баримт бичгийн нэр, төрөл	Тоо
1	Шинээр болон шинэчлэн найруулсан хууль тогтоомжийн төсөл	14
2	Дүрэм, журмын төсөл	10
3	Стандарт, нормын төсөл	11
4	Хөтөлбөр, төлөвлөгөө, төсөл арга хэмжээний санал	8
Нийт:		43

Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/01 дүгээр захирамжийн хүрээнд тохижилт бүтээн байгуулалтын ажилд саад учруулж буй хууль тогтоомжийн судалгаа хийж, 2 хуулийн 4 зүйл заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газарт хүрүүлсэн.

Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/1329 дүгээр захирамжийн хүрээнд Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Хот байгуулалт, хотын стандартын газартай хамтран Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийг шинэчлэн найруулах хуулийн төсөл болон үзэл баримтлалын төсөлд санал боловсруулж хүрүүлсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор баталсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 7 заалт бүхий санал, "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах жишиг зардлыг тооцох тухай" Барилга, хот байгуулалтын сайдын тушаалын төсөл зэргийг боловсруулж, Нийслэлийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 01/135 дугаар албан бичгээр Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлсэн.

Нийслэлийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн А/1459 дүгээр захирамжаар хяналт шалгалтын эрх зүйн орчныг сайжруулах санал, зөвлөмж боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдаж, нарийн бичгийн даргаар тус газрын дарга томилогдон ажиллаж байна. Төрийн хяналт шалгалтын тухай хууль болон холбогдох 5 хууль тогтоомжийн 15 зүйл, заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг хуулийн төсөл, зөвлөмжийн хамт боловсруулж, ажлын хэсгийн ахлагч Нийслэлийн Засаг даргын Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Т.Даваадалайд танилцуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

2.3. Үндсэн чиг үүргийн хүрээнд нийслэлийн удирдлагад хууль, эрх зүйн дэмжлэг үзүүлэх, хууль, шүүхийн өмнө төлөөлөх

Хариуцсан чиг үүргийн хүрээнд Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд нийт 10 хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хууль тогтоомжийн дагуу тайлбар, нотлох баримтыг хүргүүлж хариуцагчаар оролцсон. Үүнээс 8 хэрэг эцэслэн шийдвэрлэгдсэн буюу шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон, хянан шийдвэрлэгдэх шатанд хэлэлцэгдэж байгаа 2 хэрэг байна. Одоогоор Нийслэлийн Засаг даргыг төлөөлж оролцох хэрэг гараагүй байна.

2.4. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн;

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын дагуу байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг нийт 5 бүлэг, 32 зорилт 91 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн 2024 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаар батлуулж, эхний хагас жилд 91,1 хувьтай хэрэгжсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 81 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн “Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийг өөрчлөн байгуулах тухай” А/430 дугаар захирамж, 2024 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн “Дүрэм шинэчлэн батлах тухай” А/654 дүгээр захирамжийн дагуу газрын үндсэн чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт орсонтой холбогдуулан газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 24 зорилт, 64 арга хэмжээг төлөвлөн шинэчлэн боловсруулж, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаар 2024 оны 06 дугаар сарын 24-ний өдөр батлуулсан.

2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн биелэлтийг **95.3** хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлж, 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 01/1000 дугаар албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт хүргүүлэв.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ зорилт тус бүрээр:

№		Зорилт	Арга хэмжээ	Үүнээс:						Хувь
				100%	90%	70%	50%	30%	0%	
1	Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ	6	8	6	1	-	1	-	-	92%
2	Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ	13	42	30	9	1	1	1	-	94%
3	Дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ	3	9	9	-	-	-	-	-	100%
4	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах хүрээнд хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ	2	5	5	-	-	-	-	-	100%
Нийт:		24	64	50	10	1	2	1	-	95.3

2.5. Байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө болон нийслэлийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөний биелэлт, төсвийн гүйцэтгэл

Зөрчлийн тухай хуулийн дагуу барилга, дэд бүтцийн хяналтын улсын байцаагчдын тавьсан торгууль, шийтгэврийн орлогыг Нийслэлийн төсөв (100200000911-Хүү, торгуулийн орлогын данс)-т төвлөрүүлж байна. 2024 онд нийт 750,000,000 төгрөгийн торгууль ногдуулж, 543,700,000 төгрөгийн орлогыг нийслэлийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Санхүүгийн үйл ажиллагаанд төсөв, санхүүгийн сахилга батыг чанд мөрдөж, төсвийн зардлыг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж, санхүүгийн тайлан мэдээг тухай бүр хугацаанд нь тайлагнаж, шинээр авлага, өр төлбөр үүсгээгүй, он дамжсан, насжилт өндөртэй өр, авлага үүсгээгүй ажилласан. Тус газарт 2024 онд 3,633,605,800 төгрөгийн санхүүжилт

батлагдсанаас жилийн эцсийн байдлаар 2,511,275,271 (70%) төгрөгийн гүйцэтгэл гарган, 1,122,330,529 (30%) төгрөгийн хэмнэлттэй ажилласан байна.

Батлагдсан төсвийн хүрээнд байгууллагад шинээр бий болсон 94,496,500 төгрөгийн үндсэн хөрөнгийг нийслэлийн өмчид бүртгүүлсэн.

2.6. Төрийн захиргааны албан хаагчдын ажлын гүйцэтгэл, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэсэн байдал

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”, 2023 оны 301 тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”, Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны “Аргачлал, загвар батлах тухай” 98 дугаар тушаалын дагуу албан хаагчдын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх үнэлгээний хуудас, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хагас жил тутам дүгнэх ажлыг Үнэлгээний баг зохион байгуулж, ажлын үр дүнгээр маш сайн үнэлгээ авсан албан хаагчдад үр дүнгийн урамшуулал олгож ажилласан. Үүнд:

- 1) Албан хаагчдын 2024 оны эхний хагас жилийн ажлын гүйцэтгэл, үр дүнгийн үнэлгээний дагуу Нийслэлийн Хяналт шалгалтын газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн “Урамшуулал олгох тухай” А/26 дугаар тушаалаар төрийн захиргааны 39, төрийн үйлчилгээний 7, нийт 46 албан хаагчид холбогдох урамшууллыг тооцож олгосон.
- 2) Албан хаагчдын 2024 оны жилийн эцсийн ажлын гүйцэтгэлийг үнэлж дүгнэх, мэдээлэх чиг үүрэг бүхий Үнэлгээний багийн хурлыг 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулж, холбогдох журмын дагуу “Маш сайн” үнэлгээний ангилалд хамрагдсан 85 хувиас дээш оноо авсан тус газрын 6 хэлтсийн нийт 46 албан хаагчдын гүйцэтгэлийн үнэлгээг хянаж баталгаажуулав. Нийслэлийн Хяналт шалгалтын газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн “Гүйцэтгэлийн урамшуулал олгох тухай” А/78 дугаар тушаалаар төрийн захиргааны 36, төрийн үйлчилгээний 10 албан хаагчид холбогдох урамшууллыг тооцож олгосон.

2.7. Байгууллагын үйл ажиллагааны зардал хямдруулах, төсөв хэмнэх чиглэлээр зохион байгуулж, үр дүнд хүрсэн бодитой ажил

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 81 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн “Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийг өөрчлөн байгуулах тухай” А/430 дугаар захирамжийн хүрээнд тус газрын цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал хэмнэгдсэн.

Цалингийн сангаас хэмнэсэн зардлаас 300,000,000 төгрөгийг зардал хооронд шилжүүлэх тухай хүсэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 01/641 дугаар албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү хөрөнгө оруулалтын газар, Санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлж, шийдвэрлүүлсэн. Уг санхүүжилтийг байгууллагын албан хэрэгцээнд нэн шаардлагатай бичиг хэрэг, шатахуун, урсгал засвар, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, багаж, техник хэрэгсэл худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үүрэг бүхий үнэлгээний хороог байгуулж, худалдан авах ажиллагааны талаарх хууль тогтоомжийн хүрээнд тендер шалгаруулалтыг зохион байгуулж ажиллав.

2.8. Хяналт шалгалтын байгууллагаас ирүүлсэн санал зөвлөмж, түүнийг хэрэгжүүлсэн байдал

Нийслэлийн Дотоод аудитын албанд байгууллагын 2020-2022 оны санхүүгийн холбогдох баримтуудыг хүлээлгэн өгч явцын аудитын шалгалтад хамрагдаж, аудитын дүгнэлтээр “Хангалттай” үнэлгээг авсан. Аудитын шалгалтаас өгсөн үүргийн дагуу Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэст торгууль, шийтгэлийн орлого төвлөрүүлэх данс нээлгэх тухай хүсэлт гаргаж, нийслэлийн төрийн сангийн дансанд төвлөрүүлэн, тайланг сар бүр тайлагнаж байна.

Нийслэл дэх Төрийн аудитын газарт байгууллагын 2023 оны санхүүгийн тайланг 2024 оны 01 дүгээр сарын 23-ний өдрийн 01/89 дугаар бичгээр хүргүүлж, аудит хийлгэн, 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 168 дугаартай Аудитын дүгнэлтээр “Өөрчлөлтгүй” дүгнэлтийг хүлээн авсан. Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд өгсөн аудитын дүгнэлт, зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 02/454 дүгээр албан бичгээр Нийслэл дэх Төрийн аудитын газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газарт тус тус хүргүүлсэн.

Нийслэл дэх Төрийн аудитын газраас 2024 оны 09 дүгээр сард зохион байгуулсан “Төрийн байгууллагуудын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөө” аудитад хамрагдаж, байгууллагын 2019-2023 оны үйл ажиллагааны тайлан, бүтэц баталсан тушаал, шийдвэрүүд, албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн тайлан, албан тушаалын тодорхойлолт, хүний нөөцийн үйл ажиллагаанд холбогдох судалгаа мэдээллийг нэгтгэн тогтоосон хугацаанд хүргүүлсэн.

Нийслэл дэх Төрийн аудитын газраас байгууллагын 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн завсрын үеийн аудитын шалгалтад 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр хамрагдаж, аудитаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан газрын даргаар батлуулж, хугацаанд нь бүрэн хэрэгжүүлсэн.

2.9. Үндсэн чиг үүргийн биелэлт, үр дүнд хийсэн дотоод аудит, хяналт шалгалт, дүгнэлт

Байгууллага, хэлтсүүдийн үндсэн чиг үүргийн хэрэгжилтэд хяналт тавих, гүйцэтгэлийг хянах, үнэлэлт дүгнэлт өгөх, зөрчил дутагдлыг арилгуулах, зөрчил дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор газрын удирдлагаас баталсан удирдамж, үүрэг чиглэлийн дагуу дараах шалгалтыг зохион байгуулсан. Үүнд:

➤ Газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн “Дотоод хяналт шалгалт зохион байгуулах тухай” А/65 дугаар тушаалаар хэлтсүүдийн дүрмээр хүлээсэн чиг үүрэг болон өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулсан. Дотоод хяналт шалгалт зохион байгуулах удирдамж, хуваарийн дагуу үндсэн 6 чиглэл, 9 шалгуур үзүүлэлтээр зохион байгуулж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, ажил сайжруулах санал, зөвлөмжийг хүргүүлсэн.



➤ Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Барилгын тухай хууль, болон холбогдох бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийн хүрээнд Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтэс болон Дэд бүтцийн стандарт хяналтын хэлтсийн 2024 оны 03 дугаар сараас 05 дугаар сарыг дуустал 3 сарын хугацаанд хэрэгжүүлсэн зөрчил шалган шийдвэрлэх талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж, санал дүгнэлт зөвлөмжийг газрын даргын дэргэдэх удирдлагын зөвлөлийн 3 дугаар хурлаар танилцуулсан.

➤ Хяналт шалгалтын үйл ажиллагааны хүртээмж, үр нөлөөтэй байдлыг дээшлүүлэх, хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээний хэрэгжилтийг хангуулах зорилгоор газрын даргын 2024 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн 01 дугаартай албан даалгавар батлагдсан. Барилга, дэд бүтцийн 11 чиглэлээр зөрчил дутагдлыг арилгуулах албан шаардлага болон албан даалгаврын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж газрын даргын дэргэдэх удирдлагын зөвлөлийн 5 дугаар хурлаар танилцуулсан.

2024 оны 01 дүгээр сараас эхлэн 09 дүгээр сарыг дуустал нийт 9 сарын хугацаанд хяналт шалгалтаар илэрсэн 2100 зөрчил дутагдлыг арилгуулахаар улсын /ахлах/ байцаагчийн нийт 315 албан шаардлагыг хүргүүлж, хэрэгжилтийг 80.4 хувь ханган ажилласан байна. Харин зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны хүрээнд нийт эрх бүхий 26 албан тушаалтны 149 албан даалгавраар 256 зөрчил шийдвэрлэх арга хэмжээг 79.7 хувиар хэрэгжилтийг хангуулж, 350 сая 800 мянган төгрөгний торгуулийн орлого төвлөрүүлсэн байна. Тус газарт ирүүлсэн албан бичгийн 48 хувийг барилгын салбар, 13 хувийг дэд бүтцийн салбар, үлдсэн 39 хувийг бусад үйл ажиллагааны чиглэл эзэлж байна.

Хүснэгт. Албан шаардлага болон албан даалгаврын хэрэгжилт

№	Хэлтэс		Албан шаардлага				Албан даалгавар				
	Нэр	Улсын /ахлах/ байцаагч	Нийт албан шаардлага	Зөрчил дутагдал (тоо)	Биелэлт (тоо)	Биелэлт (хувь)	Нийт албан даалгавар	Торгууль (төг)	Зөрчил (тоо)	Биелэлт (тоо)	Биелэлт (хувь)
1	БСАБХХ	13	204	1185	1007	85.0	123	302,600,000	204	176	86.3
2	ДБСХХ	13	111	915	681	74.4	26	48,200,000	52	38	73.1
Нийт:		26	315	2100	1688	80.4	149	350,800,000	256	214	79.7

Албан шаардлагын биелэлтийг тухай бүр албан бичгээр авч бүртгэн, өмнөх шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгуулах, албан шаардлагын биелэлтийг хянах гүйцэтгэлийн хяналтыг сайжруулах, мөн тайлан судалгааг гаргахдаа хугацааг бүрэн хамруулах, улсын хяналтын байцаагчдын ажил хүлээлцэх ажиллагааг хариуцлагатай зохион байгуулах, өөр газраас шилжин ирсэн гомдол мэдээллийг тухай бүр нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх, байгууллагын хэмжээнд хяналт шалгалтын бүртгэлийн нэгдсэн загвар маягтыг мөрдөх талаар, барилга, дэд бүтцийн хяналтын салбарын хүний нөөцийг бүрдүүлэх, ялангуяа барилгын техникийн хяналтын улсын байцаагчийг тогтвор суурьшилтай ажиллуулах, ачааллыг тэнцвэржүүлэх талаар анхаарч ажиллах талаар зөвлөмж хүргүүлсэн.

Байгууллагын албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулах чиглэлээр иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлээгүй, шийдвэрлэх явцад ёс зүйн зөрчил гаргасан, тайлан мэдээг дээд шатны байгууллагад хугацаанд нь хүргүүлж ажиллаагүй үндэслэлээр Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу “хяналтын шар, улаан хуудас”-ыг нийт 34 албан хаагчдад олгож, дахин зөрчил гаргахгүй байх талаар заавар зөвлөмж өгч, арга зүйгээр ханган ажиллаж байна.

2.10. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт

2.10.1. Хүний нөөцийн удирдлага, зохион байгуулалтын хүрээнд: 2024 онд газрын бүтэц, чиг үүрэгт 2 удаагийн өөрчлөлт орсонтой холбогдуулан төрийн захиргааны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын шинээр батлуулах 12, өөрчлөн батлуулах 46, нийт 58 албан тушаалын тодорхойлолтын төслийг боловсруулж, 2024 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 02/380 дугаар албан бичгээр Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлд хүргүүлсэн.

2024 онд хүний нөөцийн чиглэлээр нийт 110 тушаал боловсруулснаас 26 албан хаагчийг албан тушаалд шинээр болон дэвшүүлэн томилж, 2 албан хаагчийг байгууллага хооронд шилжүүлж, 3 албан хаагчийг нэгж хооронд шилжүүлж, 16 албан хаагчийг Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу албан тушаалаас чөлөөлсөн байна.


Албан үүргээ хангалтгүй биелүүлсэн 9 албан хаагчид Төрийн албаны тухай хууль болон Нийслэлийн Хяналт шалгалтын газрын хөдөлмөрийн дотоод журмын дагуу сахилгын шийтгэл ногдуулсан байна.

2.10.2. “Хяналт шалгалтын газрын албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн хүрээнд: Нийслэлийн Хяналт шалгалтын газрын 2024 оны “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг 2 бүлэг, 13 арга хэмжээг төлөвлөн шинэчлэн боловсруулж, 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдөр газрын даргаар батлуулж хэрэгжилтийг ханган ажиллав.

Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх хүрээнд: Албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх сургалтад хамруулах хүрээнд Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас зохион байгуулсан **28** сургалт, семинар, зөвлөгөөнд албан хаагчдыг хамруулсан байна.

Д/д	Сургалт, арга хэмжээний нэр	Хамтрагч байгууллага	Огноо	Албан хаагчийн тоо
1	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын танилцуулга сургалт	НХААГ	2024.01.12	2
2	Жендерийн мэдрэмжтэй төлөвлөлт	Удирдлагын академи	2024.01.16	1
3	"Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх" сургалт, хэлэлцүүлэг	ХЭҮК	2024.03.06	2
4	Хүндлэл ба эерэг харилцаа	Хувь хүний хөгжлийн институт ТББ	2024.04.02	67
5	Төрийн худалдан авах ажиллагаа болон нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль, дагалдаж батлагдсан 23 хуулийн талаарх сургалт	НЗДТГ	2024.04.12	1
6	"Хөтлөх хэргийн жагсаалт боловсруулах, албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам"-ын тухай танхимын сургалт	Нийслэлийн Архивын газар	2024.04.16	2
8	Үйлдвэрийн хаягдал бохир ус цэвэрлэх сургагч багш бэлтгэх сургалт	Монголын Мянганы сорилтын сан	2024.04.24, 2024.04.25	1
9	"Монгол бичгээр баримт бичгийг зохион бүрдүүлэх"	Хэлний бодлогын	2024.05.14	1

		үндэсний хүрээлэн, НАГ		
10	Нийслэл дэх хяналтын улсын байцаагчийн мэргэшүүлэх багц сургалт	НЗДТГ, АТГ, НПГ, НХШГ	2024.05.27- 2024.05.28	16
11	“Төрийн албан хаагчдыг чадавхжуулах нь: Хүний нөөцийн удирдлага” сэдэвт 40 цагийн цахим, танхим хосолсон сургалт	Удирдлагын академи	2024.05.27- 2024.05.29	1
12	“Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгааны тухай хуулийн төсөл”-ийн талаарх хэлэлцүүлэг	МУЗГХЭГ, Удирдлагын академи	2024.05.30	4
13	Хот байгуулалт, төлөвлөлтийн эрх зүй сэдэвт сургалт	Монгол Хуульчдын холбоо	2024.05.30	2
14	УУХҮЯ-ны салбарын улсын /ахлах/ байцаагч нарыг чадавхжуулах сургалт	Нийслэлийн Прокурорын газар	2024.06.07	3
15	“Монгол бичгийн дунд шатны шат”-ны 30 цагийн сургалтын хөтөлбөр	Хэл Иргэншлийн Эрдмийн Хүрээлэн	2024.09.09- 2024.10.04	10
16	“Мэдээлэл холбооны салбарын өнөөгийн байдал, хөгжлийн чиг хандлага” сэдэвт сургалт	НЗДТГ	2024.09.30	1
17	Албан хэрэг хөтлөлт, архивын ажилтны мэргэшүүлэх сургалт	Архивын Ерөнхий газар	2024.10.01- 2024.10.31	2
18	Gas safety-2024 сургалт	АҮЭБЯ	2024.10.24	3
19	“Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт тулгарч буй асуудал, шийдэл” сэдэвт сургалт, семинар	Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төв	2024.11.13	1
20	“Төрийн захиргааны байгууллага дахь гүйцэтгэлийн удирдлага” сэдэвт танхим, цахим хосолсон богино хугацааны сургалт	Удирдлагын академи	2024.11.13- 2024.11.27	2
21	Худалдан авах ажиллагааны мэдлэг олгох АЗ сертификаттай сургалт	Сайн худалдан авалтын зөвлөх ТББ	2024.11.22- 2024.11.23	9
22	“Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг шинэлэг арга хэлбэрээр үр дүнд суурилсан манлайллаар явуулах нь”	Нийслэлийн Прокурорын газар	2024.06.21, 2024.10.10	21
23	“MNS ISO 19011:2020.Менежментийн тогтолцоонд аудит явуулах арга зүй” сургалт	Стандарт хэмжил зүйн газар	2024.10.29- 2024.10.30	1
24	Дасгал хөдөлгөөн ба эрүүл хооллолт	Мэргэжлийн багш, дасгалжуулагч	2024.10.31	20
25	“Стресс менежмент”, Стрессгүй ажлын байр” сэдэвт сургалт	Сургагч багш Б.Баярмаа	2024.11.11	25
26	Хуримтлалтай хүн “3 дансны арга” сэдэвт сургалт	Лектор Г.Мөнгөн	2024.11.18	30
27	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа сэдэвт сургалт	Арш хур ХХК	2024.11.18	44
28	Кабелын лабораторийн тоног төхөөрөмжийг ашиглах онол, практик хосолсон сургалт	Нийслэл Түгээх Сүлжээ Компани	2024.11.25	1



Зэрэг дэв, түүний нэмэгдэл: Төрийн жинхэнэ албаны болзол, шаардлага хангасан 27 албан хаагчийн зэрэг дэвийг нэмэгдлийг шинээр болон ахиулан олгуулах санал боловсруулж, 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 01/158 дугаар албан бичгээр Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлд хүргүүлсэн. Нийслэлийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох тухай” А/369 дүгээр захирамжаар ахлах түшмэл 2, дэс түшмэл 25, нийт 27 албан хаагчийн зэргийн нэмэгдлийг шинээр болон ахиулан олгосон.

Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг: Хан-Уул дүүргийн Нэгдсэн эмнэлэгтэй хамтран нэгдсэн эмнэлгийн салбар эрүүл мэндийн 13 дугаар төвд нийт албан хаагчдыг урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэг, эрүүл мэндийн 5 төрлийн шинжилгээнд хамруулах ажлыг 2024 оны 11 дүгээр сарын 5, 7, 11-ний өдрүүдэд зохион байгуулж, тус эмнэлгийн эмч, сувилагчидтай хамтран албан хаагчдыг ажлын байранд өдрийн эмчилгээнд бүрэн хамруулсан.

Цалин хөлс, тэтгэмж урамшуулал: Монгол Улсын Засгийн газрын 2024 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дугаар тогтоолын хүрээнд газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн А/04 дүгээр тушаалаар тус газрын төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалин, нэмэгдлийг шинэчлэн баталж, цалингийн системд бүртгэн сар бүр тогтоосон хувь хэмжээгээр тооцож олгож байна.

Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын дагуу 9 албан хаагчид нийт 2.5 сая төгрөгийн мөнгөн тэтгэмж олгосон байна.

2.11. Архив, албан хэрэг хөтлөлт, хариутай болон хариугүй албан бичгийн шийдвэрлэлтийн байдал

2.11.1. Архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр: Байгууллагын архивын хэвийн үйл ажиллагааг хангах, архив, албан хэрэг хөтлөлтийн стандартыг мөрдлөг болгох, нөхөн бүрдүүлэх, арга зүйн зөвлөгөө мэдээллээр хангах, лавлагаа олгох, баримт бичгийг эргэлтэд оруулах, сан хөмрөгийн хадгалалт хамгаалалтад хяналт тавих ажлыг тогтмол зохион байгуулан ажиллаж байна. Байгууллагын албан хаагчдын дагаж мөрдөх “Архивын ажлын зохион байгуулалтын дүрэм”-ийг шинэчлэн боловсруулж, газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн А/38 дугаар тушаалаар батлуулсан.

2023 онд байгууллагын хэмжээнд үүсч хөтлөгдсөн баримтуудыг хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу Архивын санд хүлээн авч, цаасан баримт, хадгаламжийн нэгж тус бүрд баримт бичгийн нягтлан шалгалт хийж, архивын нөхөн бүрдүүлэлтийг хугацаанд нь хийсэн. Батлагдсан хуваарийн дагуу хэлтсүүдээс цаасан суурьтай 371 боть, цахим 11 баримтыг хүлээн авч, хадгаламжийн нэгжийн бүртгэл боловсруулан байгууллагын дэргэдэх Баримт бичиг нягтлан шалгах комиссын хурлаар хэлэлцүүлэн батлуулсан. Үүнд:

- Байнга хадгалах 285 боть;
- Байгууллагад хадгалах 3 боть;


- Түр хадгалах 75 боть;
- 70 жил хадгалах 8 боть.

Газрын даргын 2023 онд баталсан Үндсэн үйл ажиллагааны чиглэлээр-77 (А тушаал), Хүний нөөцийн чиглэлээр-110 (Б тушаал)-ыг цахим хувь үүсгэж, 4 хадгаламжийн нэгжээр ARCHIVE EDOC системд шивж оруулан, Нийслэлийн Архивын газрын Төрийн архивын хэлтэст төлөвлөгөөт хугацаанд буюу 2024 оны 03 дугаар сарын 13-ны өдөр хүлээлгэн өгч, Захирамжлалын цахим баримт хүлээлгэн өгсөн актаар баталгаажуулав.

Хот байгуулалт, хотын стандартын газарт бүтцээр шилжсэн хэлтсүүдийн 2019-2023 онд үүссэн нийт 123 баримтыг хүлээлгэн өгч, Нийслэлийн Архивын газарт 01/116 албан бичгээр хадгаламжийн нэгжийн жагсаалт, баримт шилжүүлсэн актыг хүргүүлэв.

Байгууллагын архивын санд 2019-2023 оны нийт 1143 цаасан суурьт хадгаламжийн нэгж хадгалагдаж байна. Үүнд: байнга хадгалах 695, түр хадгалах 424, 70 жил хадгалах 24.

Архивын сангаас нийт 1152 хуудас материалд хуулбар олгож, хуулбар үнэн тэмдгээр баталгаажуулан, бүртгэл хөтлөв.



Нийслэлийн Хяналт шалгалтын газрын архивын баримтын бүрэлдэхүүн, тоо хэмжээ, хадгалалтын талаарх тоон тайланг 2024 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 01/1071 дугаар албан бичгээр Нийслэлийн Архивын газарт хүргүүлэв.

Нийслэлийн Засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудыг нүүлгэн шилжүүлэх тухай” А/732 дугаар захирамжаар Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын цогцолбор барилга, Б блок байранд нүүж ирсэнтэй холбогдуулан тус байрны В1 давхарт байрлах байгууллагын Архивын өрөөнд архивын нягтруулсан шүүгээ 8, файлын шүүгээ 2, баримтын түрдэг тэрэг 1, хамгаалалтын шат 1 ширхгийг тус тус худалдан авч, тохижилтыг хийн, баримтыг шилжүүлж байна.




2.11.2. Хариутай болон хариугүй албан бичгийн шийдвэрлэлт: Байгууллагын хэмжээнд 2024 оны жилийн эцсийн байдлаар нийт 3773 албан бичиг ирж, үүнээс шийдвэрлэсэн 3673, судалж буй 100 албан бичиг байна. Бичгийн шийдвэрлэлт 97.3 хувийн үзүүлэлттэй. Гадагшаа төрийн байгууллага болон аж ахуй нэгж байгууллага, иргэнд нийт 1657, хариугүй бичиг 1457, хариутай 200 бичиг илгээсэн байна. Гадагш явсан бичгийг хэвлэмэл хуудсанд буулган байгууллагын архивд үлдэх хувийг үйлдэн газрын даргын гарын үсэг, тамгаар баталгаажуулан ажиллав.

2.12. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1049 дүгээр журмаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам”-ын дагуу байгууллагад ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлтийг түргэн шуурхай хуулийн үндэслэлтэй судлан шийдвэрлэх, шийдвэрлэлтийн явцад зөрчил үүсгэхгүй байх талаар албан хаагчдад тогтмол мэдээлэл өгч, хяналт тавин ажиллаж байна.

Нийслэлийн Хяналт шалгалтын газарт 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 12 дугаар сарын 25-ны өдрийг хүртэлх хугацаанд хэмжээнд нийт 2313 хүсэлтийг хүлээн авч хугацаандаа шийдвэрлэсэн 2160 буюу 93.39 хувь, шийдвэрлэх шатандаа байгаа 112 буюу 4.84 хувь, хугацаа хэтэрч шийдвэрлэсэн 41 буюу 1.77 хувь байна. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа нь 2201 өргөдөл, гомдлыг 19 хоног 10 цаг 38 минут байна.

Бүртгэгдэж ирсэн өргөдөл, гомдол, хүсэлтийн 1492 буюу 63.2 хувь гомдол байна. Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас уулзалтын нийт 10 санал ирснээс байгууллагын зүгээс холбогдох саналыг хүргүүлэн ажиллалаа. Жилийн эцсийн байдлаар нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвд 31 удаагийн албан бичгээр 7 хоног бүрийн өргөдөл, гомдлын мэдээ, мөн 1 дүгээр улирал, хагас жил, 3 дугаар улирлын тайланг хугацаанд нь хүргүүлсэн.



Өргөдөл, гомдлын тэргүүлэх агуулга:

Д/д	Агуулга	Тоо
1	Барилгын хана нураасан, бүтээц хийцийг өөрчилсөн тухай	233
2	Барилгын ашиглалтын төлөв байдлын дүгнэлт гаргуулах тухай	225
3	Барилгын ашиглалтын талаар хяналт шалгалт хийлгүүлэх тухай	186
4	Барилгын угсралтын талбайн орчны аюулгүй байдал хангуулаагүй талаар	286

5	Зөвшөөрөлгүй барилга угсралт, хог шороо ихтэй, тоос бужигнасан талаар	226
6	Барилгын ажлын гүйцэтгэлийн чанар хангалтгүй талаар	69
7	Барилгын төлөвлөлт норм дүрмийн шаардлага хангаж байгаа эсэхийг хянуулж шалгуулах	57
8	Иргэн, аж ахуй нэгж байгууллага хоорондын гэрээний үүрэг биелэгдээгүй тухай	16
9	Лифтний аюулгүй ажиллагааг шалгуулах, дүгнэлт гаргуулах тухай	252
10	Шатахуун түгээх орчмын газ, бензин, шатахууны үнэр, орчны бохирдол	74
11	Авто замын хөдөлгөөнд хүнд даацын жин тонны стандарт мөрдүүлэх	19
12	Авто замын эвдрэл гэмтэл, зам сэтэлгээ	57
13	Агааржуулалтын сэнс нь их чимээтэй, үнэр ихтэй, чанга дуу чимээ гарч, чичиргээ, үзелийн дуу чимээний тухай	69
14	Барилгын дулаан шугам хоолойны эвдрэл гэмтэл, ус дулаан	178
15	Уурын зуух техникийн шаардлага хангаж байгаа эсэх	24
16	Цахилгаан хангамжийн ашиглалт аюулгүй ажиллагаатай холбоотой	39
17	Харилцаа холбооны шугам сүлжээний ашиглалт аюулгүй ажиллагааны тухай	4
18	Шөнийн цагаар хүн амрахгүй барилга барьж байгаагаар холбоотой	120
19	Байрны зоорийн давхарт ус нэвчээд байгаа тухай	85
20	Орц гарц хааж барилга бариад барьж байгаа тухай	94

2024 оны жилийн эцсийн байдлаар байгууллагын хэмжээнд иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас нийт 2313 өргөдөл, гомдол ирүүлсэн нь 2023 онд ирүүлсэн нийт 2046 өргөдөл, гомдолтой харьцуулахад 11.54 хувиар өссөн ч нийт 2160 өргөдөл, гомдолд дурдсан асуудлыг бүх талаас нь судлан үзэж холбогдох арга хэмжээг хуульд заасан хугацаанд хууль зүйн үндэслэлтэйгээр шийдвэрлэн хариуг тухай бүр хүргүүлэн ажилласан.

Газрын хэмжээнд шийдвэрлэгдсэн нийт 2160 өргөдөл, гомдлоос 1386 буюу 59.9 хувь буюу гомдол гаргагч тал буюу иргэний талд шийдвэрлэж, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг сайжруулан ажиллав.


Мөн тус газарт хандаж ирүүлж буй өргөдөл, гомдлоос дийлэнх нь тухайн барилга, байгууламжийг улсын комисс хүлээн авахаас өмнө болон улсын комисс хүлээн авснаас хойш үүссэн иргэдийн болон тухайн барилга барьж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагын буруутай үйлдээс үүдэлтэй өргөдөл, гомдол эзэлж байна. Дээрх асуудлууд нь дүүргүүдийн Засаг даргын Тамгын газрын эрхлэх асуудлын хүрээнд хамааралтай байх тул өргөдөл, гомдлыг анх бүртгэж шилжүүлэхдээ чиг үүргийг байгууллагуудад оновчтой шилжүүлэх нь тухайн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдалд ихээхэн хамааралтай тул цаашид анхаарах шаардлагатай байна.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэг болон Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1049 дүгээр захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай журам”-ын 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэгт заасны дагуу иргэний гомдлыг шийдвэрлэх явцад зөрчил гаргасан нийт 10 албан хаагчаас 6 албан хаагчдад 2024 оны А/16 дугаар тушаалаар батлагдсан газрын хөдөлмөрийн дотоод журмын 11.4 дэх заалтын дагуу хяналтын шар хуудас олгож, 4 албан хаагчдад дахин зөрчил гаргахгүй байх талаар заавар зөвлөмж тогтмол өгч арга зүйгээр ханган ажилласан. Мөн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллаагүй албан хаагчид газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн Б/91 дугаар тушаалаар сахилгын шийтгэл ногдуулсан.

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн чанарыг сайжруулах, зөрчлийг бууруулах талаар дараах арга хэмжээг авч ажиллав. Үүнд:

- Нийслэлийн Засаг даргын 2024 оны “Иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/91 дүгээр захирамжийн дагуу газрын даргын 2024 оны А/04 дүгээр тушаалаар ажлын хэсэг байгуулагдаж, газрын хэмжээнд сүүлийн 3 жилийн хугацаанд ирсэн өргөдөл, гомдлын бүртгэл мэдээлэлд үндэслэн дүн шинжилгээ хийж, түүний дагуу шийдвэрлүүлэх арга хэмжээний саналыг нэгтгэн 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 02/159 дугаар албан бичгээр НЗДТГ-ын Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвд хүргүүлэв.
- Газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн А/18 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулагдаж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлтийн шийдвэрлэлтэд дүн шинжилгээ хийсэн. Үр дүнг нэгтгэж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг газрын даргын зөвлөлийн хуралд 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдөр танилцуулж, нийт нэгж, албан хаагчдад зөвлөмж хүргүүлэв.

Өргөдөл гомдлын давхардлыг бууруулах зорилгоор Нийслэлийн шуурхай удирдлагын төв /31-0005/-ийн диспичерийн алба болон дуудлага хүлээн авдаг албан хаагчдад Хяналт шалгалтын газрын хяналтын чиг үүрэг, өргөдөл гомдлын чиглэл, цаашид хамтран ажиллах талаар санал солилцох уулзалтыг зохион байгуулсан. Уулзалтаар түгээмэл ирүүлж буй өргөдөл гомдлын хуваарилалт, цаашид авах арга хэмжээний талаар мэдээлэл өгөв.



2.13. Байгууллагуудын дотоод удирдлагын программын ашиглалт, үр дүн

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын систем (erp.ulaanbaatar.mn)-ийн ашиглалтыг сайжруулж, байгууллагын дотоод хяналт, албан хаагчдын ажлын бүтээмжийг сайжруулах зорилгоор газрын даргын 2023 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн А/27 дугаар тушаалаар ERP системийн нийт 10 төрлийн дэд системийн хэрэглээг сайжруулах удирдамж, ажил үүргийн хуваарь батлан мөрдүүлж байна. Үүнд:


1. Байгууллагын админ;
2. Хүний нөөцийн удирдлага;
3. Цаг бүртгэл /цагийн хүсэлт шийдвэрлэх, цагийн тооцоо/;
4. Хяналт шинжилгээ, үнэлгээ;
5. Тогтоол шийдвэрийн бүртгэл;
6. Ажлын төлөвлөгөө;
7. Ажлын хэсэг, үүрэг даалгаврын бүртгэл, хяналт;
8. Өргөдөл гомдол;
9. Албан бичиг;
10. Цахим архив.

Энэхүү тушаалын дагуу дээрх дэд системээр бүртгэл, хяналтын үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлэн ажиллаж байна.

2.14. Ажилтан, албан хаагчдын ажлын сахилга хариуцлага, байгууллагын соёл, дэг журмыг сахиулах, ажлын бүтээмжийг дээшлүүлсэн байдал, үр дүн

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг байгууллагын хэмжээнд мөрдүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлж, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбогдуулан гаргасан иргэн, хуулийн этгээдийн гомдол мэдээллийг хянан шалгах, хариуцлага хүлээлгэх үүрэг бүхий байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороог газрын даргын 2024 оны А/46 дугаар тушаалаар 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, ёс зүйн дэд хорооны ажиллах дэг, үйл ажиллагааны төлөвлөгөөгөө боловсруулан батлуулсан. Байгууллагын хэмжээнд ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлж, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлж, дэд хорооны үйл ажиллагааг сурталчлан таниулах ажлын хүрээнд дараах ажлыг хэрэгжүүлэн ажиллав. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны А/109 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ”-г албан хаагчдад танилцуулж мэдээлэл хүргэв.
- Төрийн албан хаагчдын ёс зүй, ёс зүйн тухайн хууль болон холбогдох хууль, ёс зүйн хэмжээний талаарх мэдээлэл сургалтыг нийт албан хаагчдад 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулав.
- “Үндсэн хууль ба тэгш эрх” сэдвээр соён гэгээрүүлэх сургалт мэдээллийг нийт албан хаагчдад 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр зохион байгуулав.
- Монгол Улсын Засгийн газар, Жендэрийн үндэсний хороо, НҮБ-ын Хүн Амын сангийн дэмжлэгтэйгээр зохион байгуулж буй жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аяны хүрээнд “Охид эмэгтэйчүүд хаана ч аюулгүй-Шалтаг бүү тооч” уриан дор байгууллагын хэмжээнд нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулсан.




Байгууллагын албан хаагчдаас 3 гомдол, мэдээлэл хүлээн авч, тухайн ёс зүйн зөрчилд холбогдуулан 2 албан хаагчид сахилгын арга хэмжээ авах тухай шийдвэрийг газрын удирдлагад танилцуулан хариуцлага тооцов.

2.15. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Авлигаас урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө боловсруулж, биелэлтийг нэгтгэн тайлагнах чиглэлээр байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны 2024 оны төлөвлөгөөг 6 зорилтын хүрээнд 18 арга хэмжээг хэрэгжүүлэхээр боловсруулж, газрын даргаар батлуулсан. 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний 2024 оны хагас жилийн байдлаар биелэлтийг нэгтгэн албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний 2024 оны биелэлтийг нэгтгэн тайлант хугацаанд хүргүүлэн ажиллахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

ХАСХОМ (Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг)-ийг мэдүүлэх эрх бүхий албан хаагчдаас шинэчлэн болон шинээр авах, хяналт тавих ажлын хүрээнд дараах ажлыг хэрэгжүүлэв. Үүнд:


- Газрын хэмжээнд 2023 оны ХАСХОМ шинэчлэн мэдүүлэх эрх бүхий нийт 56 хаагчдын мэдүүлгийг хуулийн хугацаанд хүлээн авч хянаж баталгаажуулан тайлан мэдээг НЗДТГ-т 2024.02.19-ний өдрийн 02/169 дугаарын албан бичгээр хүргүүлэв.
- Шинээр нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн нийт 19 албан хаагчдаас ХАСУМ (Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг)-ийг хүлээн авч баталгаажуулж, Авлигатай тэмцэх газарт хянуулахаар хүргүүлсэн.
- 2024 онд шинээр томилогдсон нийт 7 албан хаагчдаас хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг авч баталгаажуулан хяналт тавьж ажиллав.



Байгууллагын цахим хуудсанд Авлигатай тэмцэх газрын пэйж хуудасны QR код, “110” тусгай дугаарын утсыг сурталчилсан постер болон Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах чиглэлээр бэлтгэсэн тв шторк, зурагт хуудас, нөлөөллийн аяны мэдээ, мэдээллийг байгууллагын албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээгээр дамжуулан иргэд олон нийтэд тогтмол мэдээлэл хүргэн ажилласан



- Шар усны үерээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээлэл;
- Барилгын материалын чанар стандартын тухай;
- Өргөх байгууламж, лифтний аюулгүй ажиллагааны тухай;
- Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/367 дугаар захирамжийн хүрээнд хотын стандартыг мөрдүүлэх тухай;
- Импортоор орж ирсэн цементийн чанар стандартад хяналт шалгалт хийсэн тухай,
- Барилга байгууламжийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүртээмжийн талаар;
- Хот төлөвлөлтийн норм дүрэм хангаагүй барилга байгууламжид хяналт шалгалт хийсэн тухай;
- Сууц өмчлөгчдийн холбоодод зөвлөмж хүргүүлсэн тухай;
- Нийслэлийн нутаг дэвсгэрт, суурьшлын бүсэд байрлалтай Шатахуун түгээх станц, автомашиныг хийгээр цэнэглэх станцуудын аюулгүйн зай хэмжээний талаар;
- Авто зам, замын байгууламжийн угсралт, шинэчлэлт, засвар арчлалтын байдалд хяналт шалгалт хийсэн тухай.



3.2. Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангасан байдал буюу шилэн дансны хөтлөлтийн байдал, үр дүн

Шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллах хүрээнд <https://shilendans.gov.mn/> цахим системд 2023 оны 4 дүгээр улирлын тайлан болон тухайн жилд байршуулсан мэдээллийг Нийслэлийн Дотоод аудитын албанд 2024 оны 2 дугаар сарын 16-ний өдрийн 01/156 дугаар албан бичгээр хүргүүлсэн.

Шилэн дансны цахим системд санхүүгийн холбогдох мэдээлэл, байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийн талаарх мэдээлэл болон барилга байгууламжийг ашиглалтад оруулах болон засвар тохижилтын ажлыг хүлээн авах комиссын бүрэлдэхүүнд ажилласан албан хаагчдын мэдээллийг сар бүр хугацаанд нь тайлагнаж, байгууллагаас оруулах нийт 70 мэдээллээс хугацаандаа-69, хугацаа хоцроосон-1, нийт гүйцэтгэл 98,65 хувьтай байна.

ШИЛЭН ДАНС

Хотын стандарт хяналт газар (8314551)

Байгууллагын хэрэгсэлт

Хяналтын санбир

Тайлангийн тоогроо

Байгууллагын оруулах мэдээлэл

Захидал

Тусламж

Тайлан үүсгэх, тохируулах / Байгууллагын хэрэгсэлчийн оруулах мэдээлэл

Хэрэгсэлчийн мэдээллийн хяналт

Нийт мэдээлэх12

Хугацаандаа Мэдээлсэн11

Хугацаа хоцорч мэдээлсэн0

Мэдээлээгүй1

Төсвийн байгууллага

Тайлант онс2024

Тэмдэглэгээний тайлбар

№	Тайлангийн нэр	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулсан хугацаа	Тайлан оруулсан өргөтгөл	Засвар ажил	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Хайлт хийх																	
Хайлт хийх																	
Хайлт хийх																	
Хайлт хийх																	
Тухай бүр																	
1	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирлыг зохицуулах, ашиг сонирлын зөрчлөл: урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдээлэл	-		CYCAATAP BOLODOO	*	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	🕒

ДӨРӨВ. БУСАД МЭДЭЭЛЭЛ

4.1. Олон нийтийн арга хэмжээ

Нийслэлийн хэмжээнд болон газрын хэмжээнд зохион байгуулагдсан үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, бэлтгэл ажил, зохион байгуулалтын арга хэмжээг хангаж ажиллалаа. Үүнд:

➤ Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/226 дугаартай захирамжийн дагуу суурьшлын бүсэд мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсээс мал гаргаж, түр саатуулах үйл ажиллагаанд гуравдугаар сарын 9, 10-ны өдрүүдэд оролцсон.


➤ Байгууллагын аварга шалгаруулах “Standart cup” 5 төрөлт спорт арга хэмжээг газрын дэргэдэх Биеийн тамир, спорт хамтлагийн зүгээс 2024 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр амжилттай зохион байгуулж, тэмцээний нийлбэр дүнгээр “Хязгааргүй баг” тэргүүн байр эзэлсэн.

➤ Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний ажлын хүрээнд “НОГООН ХОТ-ИРГЭНИЙ ОРОЛЦОО” уриатай Баянзүрх дүүргийн 28 дугаар хороо, Олон улсын эко цэцэрлэгт хүрээлэн “IGM” -ийн талбайн тодорхой байршилд хаврын мод тарих аянд нэгдэн байгууллагын зүгээс 100 ширхэг хайлаас тарьсан.



➤ Нийслэлийн хэмжээнд зохион байгуулагдсан “Хотоо угаая” уриатай хаврын их цэвэрлэгээнд дөрөвдүгээр сарын 12-ны өдөр оролцож Сүхбаатар дүүрэг, Соёлын төв өргөөний арын зам, Ерөнхий сайд Амарын гудамжны баруун уулзвараас зүүн уулзвар хүртэл нийтийн эзэмшлийн 310 метр талбайг цэвэрлэх ажлыг зохион байгуулав.

➤ Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас баталсан удирдамж, хуваарийн дагуу 90’ минутын цэвэрлэгээ арга хэмжээнд 05 дугаар сарын 16-ны өдөр оролцож, “Энхтайвангийн гүүр”-ээс баруун тийш Нарны гүүр хүртэлх Дунд голын хойд хэсгийг цэвэрлэн тайлан мэдээг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Орчны бохирдол хог хаягдлын удирдлагын хэлтэст хүргүүлэв.



➤ Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчдын дунд 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулсан танин мэдэхүйн хөгжөөнт UB QUIZ-385 тэмцээнд 2 багийн бүрэлдэхүүнтэй оролцов.

➤ “Улаанбаатар Марафон-2024” олон улсын гүйлтийн тэмцээн 2024 оны 05 дугаар сарын 25-ны өдөр Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулагдаж 5км, 21км төрөлд тус тус амжилттай оролцлоо.



4.2. Санаачлан хэрэгжүүлсэн онцлох ажил

1) Комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэв.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 81 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийг өөрчлөн зохион байгуулах тухай А/430 захирамжаар байгууллагын нэр өөрчлөгдсөнтэй холбоотой Нийслэлийн Засаг даргын 2022 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн А/861 дүгээр захирамжийг Нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” А/503 дугаар захирамжаар шинэчлэн батлуулсан.

Барилга байгууламжийг ашиглалтад оруулахад 15 байгууллагын 17 төлөөлөл комиссын гишүүнээр ажилладаг байсан бол дээрх захирамжаар 13 байгууллагын 16 төлөөлөл байхаар шинэчлэв.

Ажлын үзүүлэлт	2018-2020	2020-2023	2024
Бүрэлдэхүүн байгууллагын тоо	14	15	13
Гишүүний тоо	36	17	16

2) Улсын байцаагч нарыг мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэв.

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагад ажиллаж буй хяналтын улсын байцаагч болон төрийн албаны тусгай шалгалт өгч нэр дэвшүүлэн шинээр томилогдох улсын байцаагч нарыг мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр бий болгох талаар тус газраас санаачилж, сургалтын агуулга, мөн тэтгэвэрт гарсан улсын ахлах байцаагчдыг сургагч багшаар ажиллуулах тухай саналыг 2023 оны 01/1059, 2024 оны 01/348 дугаар албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. Тус саналын дагуу 2024 оны 05 дугаар сарын 27, 28-ны өдрүүдэд Төрийн захиргааны төв байгууллагууд, Нийслэлийн Прокурорын газар, Авлигатай тэмцэх газар, Нийслэлийн Хүний нөөцийн хөгжлийн төвтэй хамтран “Хяналтын улсын байцаагч нарыг мэргэшүүлэх сургалт”-ыг зохион байгуулж, газрын дарга С.Төмөрдулам “Хяналт шалгалтын тогтолцоог сайжруулах шаардлага”

сэдвээр илтгэл тавьж мэдээлэл өгөв. Тус мэргэшүүлэх сургалтад 7 агентлагийн нийт 76 улсын байцаагч хамрагдаж гэрчилгээ гардаг авснаас, тус газрын 13 улсын байцаагч хамрагдсан.



3) Төрийн хяналт шалгалтын тогтолцоог сайжруулах хөтөлбөр боловсруулав.

Барилга, дэд бүтцийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа бизнес эрхлэгч иргэн, хуулийн этгээдийн үүрэг хариуцлагыг өндөржүүлэх, хяналтын байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, төрийн бус байгууллага, олон нийтийн хамтын хяналтын тогтолцоог бэхжүүлэх, хяналт шалгалтын давхардлыг арилгаж, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хяналт шалгалтын үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор Хяналт шалгалтын газрын даргын 2024 оны А/30 дугаар тушаалаар “Барилга, дэд бүтцийн болон бусад хяналтын салбарын хяналт, шалгалтын тогтолцоог сайжруулах хөтөлбөр боловсруулах” ажлын хэсэг байгуулсан.

Төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд дараах нийтлэг тулгамдсан асуудал байна. Тухайлбал, хяналтын байгууллагын хүний нөөцийн чадавх, мэргэшсэн, тогтвортой байдал суларсан, 2022 онд мэргэжлийн хяналтын байгууллага татан буугдсантай холбогдуулан хяналт шалгалтын эрх зүйн орчин хангалтгүй, нэгдсэн удирдлага, зохион байгуулалт суларснаас иргэний хууль ёсны эрх, ашиг сонирхлын зөрчил нэмэгдэх болсон, төрийн хяналт шалгалтын байгууллагуудын хяналтын давхардал ихтэй, зарим салбарт төрийн хяналт орхигдох, өргөдөл, гомдол бүрэн шийдвэрлэгдэхгүй орхигдох, хоорондоо шилжүүлдэг, төрийн болон төрийн бус мэргэжлийн бусад байгууллагуудын уялдаа, холбоо, хамтын хяналтын тогтолцоо сул болсноос барилга, дэд бүтцийн салбарын оролцогчдыг хариуцлагажуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх.

Иймд хяналт шалгалтын тогтолцооны үр нөлөөтэй байдлыг судалж, төрийн хяналт шалгалтын үйл ажиллагааг сайжруулах хэрэгцээ бий болж байна.

Хяналт шалгалтын газар нь 2022-2024 оны байдлаар нийт 9500 гаруй объектод хяналт шалгалтыг хийж (давхардсан тоогоор), 1346 эрх зүйн акт үйлдэж, зөрчилд 970.0 сая гаруй төгрөгийн торгууль ногдуулан ажилласан боловч барилга, дэд бүтцийн салбартай холбоотой өргөдөл гомдол, зөрчлийн талаарх мэдээлэл 2022 онд-2582, 2023 онд-5589, 2024 онд 6064 үзүүлэлттэйгээр буурахгүй байгаа нь тухайн салбар дахь хууль, норм дүрэм, стандартын хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна.

“Барилга, дэд бүтцийн салбарын хяналт шалгалтын тогтолцоог сайжруулах хөтөлбөр (2025-2029 он)”

Хөтөлбөрийн зорилго: Төрийн хяналт шалгалтын үр нөлөөтэй байдлыг дээшлүүлэх, хяналт шалгалтын давхардлыг арилгах, дэвшилтэд техник технологид суурилсан

хөндлөнгийн, хараат бус хяналт шалгалтын тогтолцоог бий болгоход энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

Хөтөлбөрийн хүрээнд 5 зорилт, 21 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төслийг боловсруулсан. Үүнд:

1. Төрийн хяналт шалгалтын үйл ажиллагаанд цахим хяналтыг нэвтрүүлэх;
2. Төрийн хяналт шалгалтын хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх, хариуцлагын тогтолцоог сайжруулах хүрээнд эрх зүйн орчныг боловсронгуй болгох;
3. Төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын уялдаа холбоог сайжруулж, хамтын хяналтын тогтолцоог бэхжүүлэх;
4. Хяналт шалгалтын байгууллагын мэргэшсэн, тогтвортой хүний нөөцийг бүрдүүлэх, санхүүгийн хувьд чадавхтай, хараат бус, бие даасан тогтолцоог бүрдүүлэх;
5. Дэвшилтэт техник технологи бүхий лабораторийг бий болгож, баталгаажсан үр дүн бүхий хяналтын үйлчилгээг иргэн, аж ахуй нэгж байгууллагад үзүүлэх.

Хөтөлбөрийн хэрэгжүүлснээр гарах үр дүн:

- Төрийн хяналт шалгалтын хүртээмжтэй байдал, иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хариуцлага нэмэгдэж, хууль тогтоомжийн хэрэгжилт сайжирна;
- Төрийн хяналт шалгалтын үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлж цахим хяналтад суурилсан хялбар системийг үйл ажиллагаанд нэвтрүүлнэ;
- 3.Төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын уялдаа холбоо нэмэгдэж, хамтын хяналтын тогтолцоо бэхэжнэ;
- Чадвартай бөгөөд мэргэшсэн, тогтвортой хүний нөөцийг хяналтын байгууллагад бүрдүүлнэ;
- Шинжлэх ухаанд суурилсан, баталгаажсан үр дүн бүхий хяналтын үйлчилгээг иргэн, аж ахуй нэгж байгууллагад үзүүлнэ;
- Иргэний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн хэрэгжилт сайжирч, барилга, дэд бүтцийн болон салбарын бусад хяналтын тогтолцоо боловсронгуй болно.

Хөтөлбөрийн төслийг Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх асуудлын жагсаалтад оруулж, бэлтгэл ажлыг ханган Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж батлуулах танилцуулга, холбогдох шийдвэрийн төслийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэн хянуулж байна.

4) Төрийн хяналт шалгалтын аппликейшн нэвтрүүлж эхлэв.


Нийслэлийн Хяналт шалгалтын газар нь барилга, дэд бүтэц, орчны аюулгүй байдлын чиглэлээр төрийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Эрх бүхийн улсын байцаагч нар хяналт шалгалт хийсэн объектын бүртгэлийг цахимаар хөтлөх, мэдээллийн сан үүсгэх, бүртгэлийг хялбаршуулах, байршил, тоон үзүүлэлт, үр дүнг тайлагнах боломжтой гар утас болон вебд суурилсан аппликейшн хөгжүүлэх ажлыг “Промакс” ХХК-тай хамтран 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрөөс гэрээг байгуулж эхлүүлсэн.

Дээрх аппликейшнийг нэвтрүүлснээр хяналт шалгалт хэрэгжүүлж буй улсын байцаагч нарын ажлын цаг ашиглалтыг сайжруулах, мэдээллийн сан үүсгэх, шалгалт хийсэн байршил, тоон үзүүлэлт, үр дүнг тайлагнах, гүйцэтгэлийг хянах ач холбогдолтой юм.


Хяналт шалгалтын аппликейшн (улсын байцаагч нарын хөтлөх)

- Нэвтрэх /өөрийн нэр, нууц үгээр нэвтэрнэ/
- Байцаагчийн хэсэг

- Хяналт шалгалт хийсэн объектын бүртгэл хийх /Төлөвлөгөөт, Урьдчилан сэргийлэх, Гүйцэтгэлийн, Төлөвлөгөөт бус/
 - Нийт 44 төрлийн шалгалтын мэдээлэл форум бөглөж илгээнэ.
 - Илгээсэн мэдээллүүдээ шүүж харна.
- Үүрэг даалгавар
 - Эрх бүхий албан тушаалтнаас ирсэн үүрэг даалгавар;
 - Үүрэг даалгаврын биелэлтийг илгээнэ.





Хяналт шалгалтын өдөр тутмын үйл ажиллагааны мэдээлэлд шинжилгээ хийхэд туслах график, тоон, газрын зураг дээрх байршлын мэдээллийг нэг дор хянах, хяналт шалгалтын үр дүнг нэгтгэн харуулах төрөл бүрийн тайлан, шинжилгээг урьдчилан бэлтгэсэн загварын дагуу харуулах бөгөөд олон төрлийн файл хэлбэрээр татаж ажлын хэрэгцээнд ашиглах боломжийг олгоно.



5) Нийслэлийн хэмжээнд мөрдөгдөх “Барилгын ажлын аюулгүй ажиллагааны журам”-ын төсөл боловсруулав.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын 2024 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн “Эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангуулах тухай” 01/37 зөвлөмжийн хүрээнд Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5-т заасан дагуу Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 195 дугаар тушаалаар батлагдсан “Барилгын ажлын аюулгүй ажиллагааны Үлгэрчилсэн журам”-д үндэслэн нийслэлийн хэмжээнд барилгын салбарт үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд мөрдөх

“Барилгын ажлын аюулгүй ажиллагааны журам”-ын төслийг боловсруулах ажлын хэсгийг газрын даргын 2024 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн А/48 дугаар тушаалаар байгуулсан.



Журмын төсөлд мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагууд болон байгууллагын албан ёсны цахим хуудсаар иргэд, олон нийтээс санал авч нэгтгэн боловсруулж, Нийслэлийн Засаг даргын захирамжийн төслийн хамт Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газарт хүргүүлэв.

6) Барилгын гадна фасад, дулаан тусгаарлах материал үйлдвэрлэгч аж ахуйн нэгж байгууллагуудын дунд хэлэлцүүлэг зохион байгуулав.

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Нийслэлийн Онцгой байдлын газартай хамтран “Барилгын гадна фасадын материалын чанар, стандарт, өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага” сэдэвт хэлэлцүүлгийг 2024 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт барилгын материал үйлдвэрлэгч аж ахуйн нэгж байгууллагууд, барилга угсралтын ажил гүйцэтгэгчид болон мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагуудын төлөөлөл нийт 86 иргэн оролцлоо.



Дээрх хэлэлцүүлгээс гарсан саналын холбогдох байгууллагуудад хүргүүлж, Барилгын тухай, Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиудын холбогдох заалтад өөрчлөлт оруулахаар ажиллаж байна. Барилгын гадна фасадын материал үйлдвэрлэгч аж ахуйн нэгж байгууллагуудад урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийснээр чанар стандартад нийцээгүй материал, түүхий эд ашигласан, хэрэглэсэн зөрчилд хүлээх хариуцлагыг нэмэгдүүлж хяналт шалгалтаар илэрсэн дутагдлуудыг арилгуулах арга хэмжээ авсан. Үүний үр дүнд аж ахуйн нэгж байгууллагууд үйлдвэрлэлийн явцад ашиглаж байгаа даралтад хийн савны баталгаажуулалтыг норм дүрмийн дагуу батлуулахаар Хяналт шалгалтын газарт хандаж эхлээд байна.

ТАВ. ДҮГНЭЛТ

Нийслэлийн иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг сайжруулах үндсэн зорилгын дор Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Хяналт шалгалтын газар шинээр өөрчлөн зохион байгуулагдаж, барилга, хот байгуулалт, газрын харилцаа, уг салбарт орчны аюулгүй байдлыг хангуулах хүрээнд төрийн хяналт шалгалтын чиглэлээр дагнасан чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Тус газар нь Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчтай байгуулсан 2024 оны хариуцлагын гэрээний жилийн эцсийн биелэлт 92.3 хувь, байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө 95.3 хувийн хэрэгжилттэй ажиллаж, 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 01/1000 дугаар албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тайлагнасан байна.

Байгууллагын үндсэн чиг үүргийн хэрэгжилттэй холбоотой дараах нийтлэг асуудлууд бий болж байна. Үүнд:

- 2023-2024 онд тус газрын хариуцсан хяналтын чиглэлтэй холбоотой иргэдийн өргөдөл гомдол, зөрчлийн тоо төдийлөн буурахгүй, ажлын ачаалал нэмэгдэж байгаагаас үзвэл Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль болон салбарын хууль тогтоомжийн хэрэгжилт болон хяналт шалгалтын үр нөлөөг сайжруулахын тулд хууль эрх зүй, хүний нөөц, төсөв санхүүгийн талаас дорвитой арга хэмжээг санаачлан хэрэгжүүлэх шаардлага тулгарч байна.
- Барилга техникийн хяналтын улсын байцаагч нарын ажлын ачаалал харилцан адилгүй, хүний нөөцийн дутагдалтай байна.
- Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд техникийн алдаа, дутагдлууд нийтлэг илэрч байгаа нь эрх бүхий албан тушаалтнуудын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх хэрэгтэй байгааг илтгэж байна.
- Захиалагч барилгын баримт бичгийн бүрдэл дутуу, ажлын гүйцэтгэл бүрэн дуусаагүй байхад комисс ажиллуулах хүсэлт ирүүлэх;
- Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтийг гаргахдаа гүйцэтгэгчтэй хамтран ажиллаж гүйцэтгэл, өөрчлөлтийн зураг, ил далд ажлын акт, техникийн баримт бичиг зэрэг нотлох баримтыг тухай бүр бүрдүүлэх, ирүүлэх, баримт бичгийн үнэн зөв байдалд хариуцлагагүй хандах;
- Барилгын үе шатны ажлын явцад ашиглагчийн саналаар зураг төслийн төлөвлөлтийг дур мэдэн өөрчилдөг, өөрчлөлтийн зураг, ил далд ажлын акт, техникийн баримт бичгийг тухай бүр бүрдүүлж, хянан баталгаажуулдаггүй.

ЗУРГАА. ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ, САНАЛ

Захиргаа, дотоод хяналтын хүрээнд:

- Үндсэн чиг үүргийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавих тогтолцоог бүрдүүлж, хэвшүүлэх;
- Албан хаагчдын ажлын ачаалал, дотоод ажлын чиг үүргийн хуваарилалтыг оновчтой зохион байгуулах;
- Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах;
- Албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт, нөлөөллийн ажлыг үе шаттай зохион байгуулах.

Хүний нөөцийн үйл ажиллагааны хүрээнд:

- Албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн батлуулах;

- Сул орон тоог нөхөх, сонгон шалгаруулалтыг зохион байгуулж хүний нөөцийг бүхдүүлэх;
- Албан хаагчид, улсын байцаагч нарыг дадлагажуулах, мэдлэг ур чадварыг сайжруулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх.

Хяналт шалгалтын үр нөлөөг сайжруулах хүрээнд

- Хяналт шалгалтад шаардлагатай баталгаат, үнэн зөв мэдээллийн эх үүсвэр, хүртээмжийг нэмэгдүүлэх;
- Хяналт шалгалтын бүртгэл, мэдээллийн системийн хөгжүүлэлтийг хийж, үйл ажиллагаанд нэвтрүүлэх;
- Зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагаанд гарч буй нийтлэг зөрчил, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсэд дүн шинжилгээ хийж, зөрчлийг бууруулах ажлыг үе шаттай төлөвлөх;
- Хяналтын улсын байцаагчдыг сургах, мэргэшүүлэх багц хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;
- Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл гомдол, хүсэлтэд дүн шинжилгээ хийж, бууруулах арга хэмжээг авч ажиллан, орчны эрсдлийг бууруулж ажиллах;
- Төрийн хяналт шалгалтын үр дүнд суурилсан зөрчлийг бууруулах урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллах.

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах чиг үүргийн хүрээнд

- Барилга байгууламж ашиглалтад оруулах комиссын ажиллах зардлын хэмжээг барилга байгууламжийн төвөгшил, хэмжээг харгалзан тогтоох, барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг төлбөртэй үйлчилгээ болгох;
- Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийг шинэчлэх.

ТАНИЛЦСАН:
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ, ТАЙЛАН
ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



С.ЭНХБАЯР

Б.МӨНХБАЯР

М.ГАЧМАА